



АГУУЛГА

4	Мэндчилгээ
6	Эрчим хүчний зохицуулах хорооны товч танилцуулга
6	Эрчим хүчний зохицуулах хорооны зохион байгуулалтын бүтэц
7	Эрчим хүчний зохицуулах хорооны удирдлага, бүтцийн нэгжүүд
10	Эрчим хүчний зохицуулах хорооны хурал
11	Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны төсөв, зардлын гүйцэтгэл
11	Эрчим хүчний зохицуулах хорооноос 2019 онд дэвшүүлсэн зорилтуудын хүрээнд хийж гүйцэтгэсэн онцлох ажлууд
16	Дотоод аудит
16	Тусгай зөвшөөрлийн зохицуулалт
17	Тусгай зөвшөөрөл олголт, сунгалт
18	Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр
18	Сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн талаар
20	2019 онд хэрэгжүүлсэн хяналт шалгалтын талаар
22	Үнэ тарифын зохицуулалт
22	Хэрэглэгчийн үнэ, тарифын зохицуулалт
25	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тарифын зохицуулалт
27	Цахилгааны спот зах зээл
30	Нэг худалдан авагчтай зах зээл
31	Цахилгааны өрсөлдөөнт зах зээл
31	Хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдал
32	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүд
34	Хэрэглэгчийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт
37	“Дулаан орчин-хэрэглэгчийн ая тух” аян
38	Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа
40	Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг
44	Хорооны 2020 оны зорилт
45	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр
46	Эрчим хүчний зохицуулах хороо 2019 онд (Фото мэдээ)



Мэндчилгээ



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАЙЛАН СЭТГҮҮЛТЭЙ ТАНИЛЦАЖ БАЙГАА ЭРХЭМ ТАНД ЭНЭ ӨДРИЙН МЭНД ХҮРГЭЭ.

2019 он Эрчим хүчний зохицуулах хорооны төдийгүй эрчим хүчний салбарын хувьд их бүтээн байгуулалтын бас их амжилтын жил болон өнгөрлөө. Монгол Улсын дулааны цахилгаан станцуудын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 6.3 тэрбум кВт.ц, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн хэмжээ 653.7 сая кВт.ц, дотоодын нийт үйлдвэрлэлийн хэмжээ 7.0 тэрбум кВт.ц болж өмнөх оны гүйцэтгэлээс 378.6 сая кВт.ц-аар буюу 5.4 хувиар нэмэгдсэн байна. ОХУ-аас худалдаж авсан импортын цахилгааны хэмжээ өмнөх оны гүйцэтгэлээс 43.6 сая кВт.ц-аар буюу 10.5 хувиар буурч 372.4 сая кВт.ц боллоо. Улсын хэмжээнд цахилгааны хэрэглээ 410.7 сая кВт.ц-аар буюу 4.9 хувиар нэмэгдэж 8.7 тэрбум кВт.ц-т хүрлээ. Мөн дулааны хэрэглээ өмнөх оноос 421.4 мян.Гкал буюу 4.3 хувиар нэмэгдэж 10.3 сая Гкал болсон байна. Өсөн нэмэгдэж байгаа цахилгааны хэрэглээг дотоодын үйлдвэрлэлээр хангах зорилтын хүрээнд “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн хүчин чадлыг 35 МВт-аас, “ДЦС-4” ТӨХК-ийн суурилагдсан хүчин чадлыг нийт 43 МВт-аар тус тус

нэмэгдүүлж, 50 МВт-ын хүчин чадалтай Сайншандын салхин цахилгаан станцыг ашиглалтад оруулан нэгдсэн сүлжээний суурилагдсан хүчин чадлыг 133 МВт-аар нэмэгдүүллээ.

Өнгөрсөн 2019 онд Эрчим хүчний зохицуулах хороо нь үндсэн үйл ажиллагаа, зорилгынхоо хүрээнд 6 зорилт дэвшүүлэн бүрэн хэрэгжүүллээ. Эрчим хүчний салбарын хууль эрх зүй, дүрэм журмыг боловсронгуй болгох чиглэлээр амжилттай ажиллаж, тодорхой үр дүнд хүрсэн жил байлаа. УИХ-аас Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж баталснаар дэмжих тарифын тогтолцооноос өрсөлдөөнт зах зээлийн зарчимд шилжүүлж, нэгдсэн сүлжээний тогтвортой байдлыг хангаж, цахилгааны үнэ тарифын огцом өсөлтийг хязгаарлаж чадлаа. Тусгай зөвшөөрлийн харилцааг зохицуулах аж ахуйн харилцааны дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, мөрдөж эхэллээ. Ингэснээр бүх төрлийн тусай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын биелэлтийг үнэлж дүгнэдэг тогтолцоонд шилжлээ. Улаанбаатар хотын

дулааны нэг худалдан авагчтай загварыг боловсруулж Эрчим хүч сайдын тушаалаар батлуулаа. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмуудыг шинэчлэн боловсруулж, Засгийн Газрын 2019 оны 181, 182-р тогтоолуудаар батлуулав. Мөн эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг тодорхойлох олон улсын эрчим хүчний удирдлагын тогтолцооны 6 бүлэг стандартыг боловсруулан, Стандарт, хэмжил зүйн газрын Эрчим хүчний техникийн хорооны хурлаар батлуулаа.

Эрчим хүчний зохицуулах хорооны гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, Улаанбаатар хотын угсармал орон сууцны дулаан, техникийг шинэчлэх төслийг Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагатай хамтран бэлтгэж, НАМА буюу хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээний сонгон шалгаруулалтад оролцож, эхний шатанд тэнцэн НАМА-гаас төслийн нарийвчилсан судалгааг хийж гүйцэтгэхэд зориулан 300 мянган ам. доллар авах боломжтой боллоо.

Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлыг бууруулах, эрчим хүч хэмнэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх сонирхлыг бий болгох зорилгоор манай хорооноос боловсруулж баталгаажуулсан "Урамшуулалт зохицуулалтын журам"-ын дагуу Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай урамшуулалт зохицуулалтын гэрээ байгуулж ажилласан. Үүний үр дүнд дотоодын үйлдвэрлэлийг 109 сая кВт.ц-аар нэмэгдүүлж 11 тэрбум төгрөгийн хэмнэлтийг бий болгож, ТЗЭ 10 компани хэмнэлтийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлэн 3.7 тэрбум төгрөгийн урамшуулал авах боломжийг бүрдүүлэв.

Тайлант онд Улаанбаатар хот болон Төв, Зүүн, Өмнөд бүсийн энгийн тоолууртай айл өрхүүд 150 кВт.ц хүртэлх хэрэглээний 1 кВт.ц цахилгааныг 134 төгрөг 28 мөнгө буюу бодит өртгөөс нь 31.0 хувиар доогуур үнээр, 151 кВт.ц-аас дээших хэрэглээг 154 төгрөг 08 мөнгө буюу бодит өртгөөс 14.2 хувиар доогуур үнээр худалдан авсан байна. Харин хоёр тарифт тоолууртай айл өрхүүд өглөөний 06 цагаас оройн 21 цаг хүртэл 140 төгрөг 18 мөнгөөр буюу бодит өртгөөс 25.5 хувиар доогуур үнээр, оройн 21 цагаас өглөөний 06 цаг хүртэл 112 төгрөг 98 мөнгөөр буюу бодит өртгөөс 57.7 хувиар доогуур үнээр цахилгаан эрчим хүчийг хэрэглэсэн байна.

Өөрөөр хэлбэл айл өрхүүд 1 кВт.ц цахилгаан эрчим хүчийг 14-56 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдан авч хэрэглэсэн бөгөөд нэг өрхөд сард дунджаар 6400 төгрөг, жилд 76 800 төгрөгийн бодит хөнгөлөлт үзүүлж өнгөрсөн 2019 онд гэхэд улсын хэмжээнд нийтдээ 663 мянган гаруй айл өрхөд 79.0 тэрбум төгрөгийн цахилгаан эрчим хүчний үнийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Мөн агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд халаалтын улиралд аймгийн төв, 10 мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын иргэдийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний үнийг 50 хувь хөнгөлж, үүнд нийтдээ 12.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн 1 кВт.ц цахилгааны борлуулалтын дундаж үнэ нэгжийн бодит өртгөөс 5 орчим хувиар доогуур байгаа бол бусад бүсийн цахилгааны дундаж үнэ нэгжийн өртгөөс 1.2-1.8 дахин доогуур түвшинд байна.

Цаашид Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн баталгаа болсон эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, 2023 он гэхэд эрчим хүчний хэрэгцээгээ дотоодын үйлдвэрлэлээр хангах томоохон зорилтын өмнө бид зогсож байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд төвийн бүсэд Багануурын дулааны цахилгаан станцын нэгж агрегатын хүчин чадлыг 200 МВт-аар хязгаарлаж, эхний ээлжинд 400 МВт-ын хүчин чадалтайгаар барих, Тавантолгойн дулааны цахилгаан станцыг 300÷450 МВт хүчин чадалтайгаар барьж, Оюутолгойн уурхайг эрчим хүчээр хангах, Ховд аймагт Эрдэнэбүрэнгийн 92 МВт хүчин чадалтай усан цахилгаан станцыг барьж, баруун бүсийн эрчим хүчний системийн хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах, ДБЭХС-ийн хүчин чадлыг 50 МВт-аар нэмэгдүүлэн өргөтгөх, зарим цахилгаан дамжуулах агаарын шугамуудыг барьж байгуулах гээд асар их бүтээн байгуулалтын ажил биднийг хүлээж байна. Мөн дэлхийн жишигт нийцсэн, нийгмийн сэтгэл зүйд тохирсон үнэ тарифын бодлогыг нутагшуулах, эрчим хүчний салбарыг зах зээлд шилжих үйл явцыг эрчимжүүлэх, өрсөлдөөнийг нэвтрүүлэх, эрчим хүчний салбарын алдагдлыг бууруулах зэрэг томоохон зорилтууд дэвшүүлэн ажиллаж байна.

Эрхэм уншигч Та бүхэн манай 2019 оны үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлантай танилцаж, бидэнд үнэтэй зөвлөгөө өгнө гэдэгт итгэлтэй байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА



Алмаликийн ТЛЕЙХАН

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



ЧИГ ҮҮРЭГ


Эрчим хүчний тухай хуулийн дагуу эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, хангах үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн дагуу эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.



ҮНДСЭН ЗОРИЛГО

Эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа, салбарын санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх болон хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалахад чиглэсэн зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоог бүрдүүлнэ.


ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ





УДИРДЛАГА

Эрчим хүчний тухай хуулийн дагуу Эрчим хүчний зохицуулах хороог орон тооны гурав, орон тооны бус хоёр, нийт таван гишүүний бүрэлдэхүүнтэй зохицуулагчид удирддаг. Зохицуулах хорооны дарга, орон тооны хоёр зохицуулагчийг эрчим хүчний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал, орон тооны бус хоёр зохицуулагчийг Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналыг тус тус үндэслэн Ерөнхий сайд томилдог болно. Эрчим хүчний зохицуулах хорооны даргаар А.Тлейхан, орон тооны зохицуулагчаар Э.Түвшинчулуун, Б.Баттулга, орон тооны бус зохицуулагчаар У.Мягмарсүрэн, Э.Самдан нар томилогдон ажиллаж байна.



АЖЛЫН АЛБА


Ажлын алба нь Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн дагуу түүний өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гарсан шийдвэр, үүрэг, даалгаврын биелэлтийг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй бөгөөд Хорооны дарга, гишүүдийг холбогдох мэдээ, баримт, судалгаагаар хангах; тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, үнэ тариф, хэмнэлтийн бодлогын талаар санал боловсруулах; тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү, эдийн засгийн байдал, зардалд болон эрчим хүч хэмнэлтийн арга хэмжээний биелэлтэд дүн шинжилгээ хийх; Хорооны эрх хэмжээнд хамаарах асуудлаар хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аппаратын удирдлага юм.



ДОТООД АУДИТЫН ГАЗАР


Дотоод аудитын газар нь Эрчим хүчний зохицуулах хорооны эрсдэлийн удирдлага, хяналтын үйл ажиллагааны үр дүнг хараат бусаар үнэлж дүгнэн, зөвлөмж өгөх замаар Хорооны үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна. Үүнд:

- Хорооны болон аймаг, Нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу явагдаж байгаа эсэх;
- Хорооны тогтоолын хэрэгжилт;
- Хорооны зохицуулагчдаас Ажлын алба, түүний нэгжийн удирдлагад өгсөн үүрэг, даалгаврын биелэлт;
- Дээд болон холбогдох бусад байгууллагаас Хороонд өгсөн үүрэг, даалгаврын биелэлт;
- Хорооны жилийн болон сарын ажлын төлөвлөгөөний биелэлт;
- Хөндлөнгийн аудитын зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээ;
- Хорооны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаа;
- Ажлын албаны чиг үүргийн хэрэгжилт;
- Хорооны жилийн үйл ажиллагааны болон төсвийн төлөвлөгөөний биелэлт;
- Эрсдэлийн үнэлгээ;
- Төлөвлөгөөт бус тусгайлан явуулах бусад аудит;




ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ХЯНАЛТЫН ГАЗАР

Тусгай зөвшөөрлийн болон хяналт шалгалтын талаар баримтлах бодлого чиглэлийг боловсруулах, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү, техник-эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, тэдгээрийн техник, эдийн засгийн үзүүлэлтүүд, эрчим хүчний хэрэглээний талаар мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх, холбогдох дүрэм, журмуудыг боловсронгуй болгох чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



ХЭРЭГЛЭГЧ, ОРОН НУТГИЙН ХЭЛТЭС

Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлаар тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын гомдол, маргааныг шийдвэрлэх, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах; аймаг, нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлүүдийн гишүүдийг томилох, чөлөөлөх ажлыг зохион байгуулах; зохицуулах зөвлөлүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, ажлын заавар, удирдамжаар хангах, үнэлэлт дүгнэлт өгч сургалт, зөвлөгөөн зохион байгуулан ажиллаж байна.




ҮНЭ ТАРИФ, ЗАХ ЗЭЭЛИЙН ГАЗАР

Эрчим хүчний үнэ тариф, зах зээлийн загвар, тогтолцооны талаар баримтлах бодлого, чиглэлээр санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрээр тарифын бүтцийг тодорхойлох, хэрэглэгчдэд худалдах үнийг тооцох; тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн тарифын саналыг хянах, тэдгээрийн тооцож гаргасан өртөг, зардлын үндэслэл, үнэн зөв байдалд үнэлгээ өгөх, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү, эдийн засгийн байдал, үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийх; цахилгаан, дулааны эрчим хүчний үнийн өсөлтийг макро эдийн засгийн түвшинд шинжилж судлах, дүгнэлт гаргах зэрэг чиглэлээр ажиллаж байна.



ЗАХ ЗЭЭЛИЙН СУДАЛГАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС

Эрчим хүч үйлдвэрлэх, түгээх, хангах үйл ажиллагаанд зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийг олон улсын түвшинд судалж нэвтрүүлэх, эрчим хүчний хэрэглээг хамгийн бага өртгөөр хангах чадавхыг бүрдүүлсэн, ашгийн зохих түвшинг хангасан, үнэ тарифын тогтолцоог бий болгох нөхцөлийг бүрдүүлэх, салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг татах, хамтын ажиллагааг хөгжүүлэх болон цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.




ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ГАЗАР

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд заасан Хорооны бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулж, холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр болон хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлж бүртгэх, эрчим хүчний хэмнэлтийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, аудитор, менежерийн эрх олгох, мэргэжлийн байгууллагыг магадлан итгэмжлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.



ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗАР

Эрчим хүчний зохицуулах хорооны хүний нөөцийг бүрдүүлэх, чадавхжуулах, мэргэшүүлэх, архив, албан хэрэг хөтлөлт, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх; Хорооноос гаргаж буй шийдвэрүүдийн хууль зүйн үндэслэлийг хангуулах; салбарын болон зохицуулалтын үйл ажиллагааг сурталчилах, хэвлэл, олон нийттэй харилцах, хэрэглэгчдэд эрчим хүчний боловсрол, мэдлэг олгох, мэдээллээр хангах; цахим мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах, боловсронгуй болгох; байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг шуурхай явуулах нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна.



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛҮҮД

Улаанбаатар хот болон 21 аймагт эрчим хүчний хангамжийн төрийн зохицуулалтыг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд хэрэгжүүлдэг. Зохицуулах зөвлөлүүд нь Эрчим хүчний зохицуулах хорооноос томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хянах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тариф, хэрэглэгчдийн үнийг батлах, эрх ашгийг хамгаалах, холбогдох дүрэм журмыг хэрэгжүүлэх хяналт тавих зэрэг эрх, үүрэгтэй ажиллаж байна.

ХОРООНЫ ХУРАЛ

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2019 онд 46 удаа урьдчилсан хэлэлцүүлэг зохион байгуулж 519 асуудал авч хэлэлцсэн байна. Мөн Хорооны хурлыг 42 удаа хийж тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, хэрэглэгчдийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үнэ тарифыг батлах, тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон хэрэглэгчид

дагаж мөрдөх дүрэм, журмуудыг батлах, үүрэг даалгавар өгөх, аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн дарга, гишүүдийг томилох болон Хорооны дотоод үйл ажиллагаатай холбоотой нийт 481 асуудлыг хэлэлцэн 590 тогтоол батлан гаргасан байна.

График 1

Хурлаар хэлэлцсэн асуудлыг хариуцсан нэгж тус бүрээр нь авч үзвэл:




График 2

Хурлаас гарсан шийдвэр буюу тогтоолыг төрлөөр нь авч үзвэл:





Хуралд оруулсан асуудлын тоо

Тогтоолын тоо



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2019 ОНЫ ТӨСӨВ, ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.18, 9.1.20 дахь заалтуудыг үндэслэн 2019 оны үйл ажиллагааны зардлын хэмжээг Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 15 дугаар тогтоолоор 4,447.8 сая төгрөгөөр, хөрөнгө оруулалтын хэмжээг 16 дугаар тогтоолоор 1,876.7 сая төгрөгөөр тус тус батлан, санхүүгийн үйл ажиллагааг явууллаа. 2019 оны санхүүгийн тайлангаар үйл ажиллагааны зардал 3,866.6 сая төгрөг буюу 13.1 хувийн хэмнэлттэй, хөрөнгө оруулалтын зардал 1,310.2 сая төгрөг буюу 30.2 хувийн хэмнэлттэй гарчээ. Үйл ажиллагааны зардлын 72.2 хувийг Хорооны ажилтан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, 5.7 хувийг аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн зардал, 4.6 хувийг албан томилолт, хэвлэл, мэдээллийн зардал, 17.5 хувийг



бичиг хэрэг, хангамжийн материал, шатахуун, албан татвар, хураамж, даатгал, харилцаа холбоо, ашиглалт, засвар үйлчилгээний зардал тус тус эзэлж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС 2019 ОНД ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ОНЦЛОХ АЖЛУУД

Нэг. Эрчим хүчний ухаалаг сүлжээ, мэдээллийн технологийг хөгжүүлэх, хэрэглэгчдийг эрчим хүчээр найдвартай хангах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах; реле хамгаалалт, автоматик, системийн тогтворжилт, хяналт, удирдлагын системийн мэргэжлийн ажилтнуудын зөвлөгөөнийг зохион байгуулах зорилтын хүрээнд;

- Цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй 30 гаруй компанид ухаалаг систем, шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх чиглэлээр тодорхой зөвлөмж боловсруулж хүргүүлсэн ба зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэв.
- Эрчим хүчний системийн реле хамгаалалт, автоматик, хяналт удирдлагын системийн мэргэжлийн ажилтнуудын зөвлөгөөнийг 2019 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Эрчим хүчний яам, Диспетчерийн үндэсний төвтэй хамтран зохион байгуулав. Зөвлөгөөнд тусгай зөвшөөрөл эзэмшигч 30 гаруй компанийн 90 гаруй төлөөлөл оролцсон бөгөөд Нэгдсэн сүлжээний реле хамгаалалт, автоматик, эрчим хүчний системийн тогтворжилтын өнөөгийн

- төлөв байдал, орчин үеийн шийдлүүд, системийн холбоо, шилэн кабелийн өнөөгийн байдал, сайжруулах арга замууд зэрэг сэдвүүдээр илтгэл, хэлэлцүүлэг хийж зөвлөмж гаргалаа. Зөвлөгөөний илтгэлүүдийг файлаар болон бичлэг хэлбэрээр ndc.energy.mn цахим хуудасны “Ухаалаг эрчим хүч” цонхонд байршуулж олон нийтэд сурталчилсан.
- Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний хөгжлийн төв, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, Диспетчерийн үндэсний төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн зэрэг байгууллагууд хамтран “Эрчим хүчний салбар дахь ухаалаг шийдлүүд-2019” нийтлэл, илтгэлийн уралдааныг монгол, англи хэл дээр зохион байгууллаа. Уралдаанд “Эрчим

хүчний үйлдвэрлэлийн ухаалаг технологи, тоног төхөөрөмж”, “Эрчим хүчний ухаалаг сүлжээ, мэдээллийн технологи, программ хангамж”, “Реле хамгаалалт, автоматик, системийн тогтворжилт, хяналт, удирдлагын систем”, “Түгээх, дамжуулах сүлжээний ухаалаг тоолуур” зэрэг сэдвийн хүрээнд 22 илтгэл ирсэн юм. Энэхүү илтгэл, нийтлэлийн уралдаанд ШУТИС-ийн ЭХС-ийн цахилгаан техникийн салбарын багш, доктор Д.Пүрэвдаш, ГУУС-ийн уулын цахилгааны салбарын багш, доктор, дэд профессор П.Ариунболор, ЭХС-ийн цахилгаан техникийн салбарын багш, доктор, профессор Ч.Нацагдорж нарын хамтран бэлтгэж танилцуулсан “Цахилгаан энергийн чанарын динамик загварчлал ба симуляторын боловсруулалт” сэдэвт бүтээл тэргүүн байр эзэлсэн юм.

- Ухаалаг эрчим хүчний жилийн хүрээнд Диспетчерийн үндэсний төвөөс эрчим хүчний



нэгдсэн сүлжээнд Өргөн хүрээний хяналтын систем (WAMS-Wide Area Management System)-ийг нэвтрүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэв.

- Дорнод аймгийн Хэрлэн сумын цахилгаан түгээх сүлжээнд нийт 12.2 мянган айл өрхийг хамруулсан ухаалаг тоолуур бүхий цогц системийг нэвтрүүлэх төсөлд дэмжлэг үзүүлж хэрэгжүүлж эхлээд байна. Ухаалаг тоолуурын систем нэвтэрснээр тус компанийн эрчим хүчний хангамжид ачааллын хяналт ба зохицуулалт хийх боломж бүрдэх, цахилгаан түгээх сүлжээний арилжааны алдагдал багасах, тоолуурын заалт авах үйл ажиллагаа хялбар болох, хангах үйл ажиллагааны зардал буурах, хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний чанар сайжрах, хэрэглэгчдэд эрчим хүчний бодит хэмнэлт бий болгох зэрэг давуу талтай юм.
- Эрчим хүчний хэрэглэгчдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах үүднээс цахим гарын авлагыг хөгжүүлж <https://info.erc.mn/> вэб сайтыг ашиглалтанд орууллаа. Тус вэб сайтад хэрэглэгчийн цахилгаан, дулааны үнэ тариф, хууль эрх зүйн мэдээлэл, дүрэм, журам, өргөдөл, гомдол гаргах заавар, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, Хорооны үйл ажиллагааны талаарх мэдээлэл, эрчим хүчний салбарын статистик үзүүлэлтүүд зэрэг цэсүүдэд хэрэглэгчдэд шаардлагатай мэдээллүүдийг тухай бүр шинэчлэн оруулж байна.

Хоёр. Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын өгөөж, техник, эдийн засгийн үр ашгийг үнэлэх, дээшлүүлэх шалгуур зарчим, үзүүлэлтүүдийг тодорхойлж хэрэгжилтэд хяналт тавих зорилтын хүрээнд;

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тарифаар бүрдүүлсэн орлогын эх үүсвэрийг хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажлуудын хүрээнд эрчим хүчний найдвартай ажиллагааг дээшлүүлэхэд үр ашигтай зарцуулж байгаа байдалд хяналт тавих, тэдгээрийн техник, эдийн засгийн үр ашгийг үнэлэх, дээшлүүлэх талаар ажлын хэсэг байгуулж ажиллалаа. Томоохон тусгай зөвшөөрөл эзэмшигч 18 компанийн үр өгөөжийн тооцоолол, судалгаанд үндэслэн хөрөнгө оруулалт, техник технологийн шинэчлэл, их засварын ажлыг тэдгээрийн өгөөж, үр ашиг, ач холбогдолд нь үндэслэн төлөвлөх, үр дүнг тооцох чиглэлээр тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрээр нэгдсэн аргачлал, маягт боловсруулж 2020 онд үр ашгийг үнэлэх, дээшлүүлэх шалгуур зарчим, үзүүлэлтийг тодорхойлох суурь судалгааг хийсэн.
- Улаанбаатар хотын дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч 60 компанийн өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 2019 оны их болон урсгал засвараар дулаан түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмжид хийх засварын ажлын график төлөвлөгөөтэй танилцаж гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллав.
- Цахилгаан сүлжээгээр дамжуулж байгаа эрчим хүчний технологийн алдагдлын норм тогтоох

үндэслэл, тооцооны аргачлалыг боловсруулав.

- Дулааны цахилгаан станцуудын тооцооны 7 инженерийг ОХУ-д “Нүүрсээр ажиллах эх үүсвэрийн түлшний зарцуулалтын норм, нормативыг тогтоох нь” сэдэвт богино хугацааны сургалтад хамруулж станцын дотоод хэрэгцээний цахилгаан, жишмэл түлшний хувийн

зарцуулалтыг төлөвлөх аргачлалын төслийг хамтран боловсруулаад байна.

- “УБЦТС” ТӨХК, “Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх” ХХК, “Хөвсгөл эрчим хүч” ХХК, “Хөвсгөл дулааны станц” ТӨХК, “Ган-Илч” ХХК-иудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж албан шаардлага, зөвлөмж өглөө.

Гурав. Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд үүрэг хүлээсэн хэрэглэгч бүрт хүрч ажиллах; эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, хэмнэлтийг урамшуулах тогтолцоог бий болгох, бодит үр дүн гаргах зорилтын хүрээнд;

- Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар, байгууллага хоорондын уялдааг хангах, хамтран ажиллах хүрээнд Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуучлалын яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар болон Олон улсын байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, эдгээр байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлийг тогтоож, оролцогч талуудын мэдээлэл солилцох уулзалтыг 2019 оны 03, 12 дугаар саруудад тус тус зохион байгуулсан.
- Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх 18 зорилт, 85 арга хэмжээний 2019 онд хэрэгжүүлэхээр тусгасан 69 арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулснаар 93 хувийн гүйцэтгэлтэй ажиллав.
- 2019 онд 100 аж ахуйн нэгж байгууллагыг шинээр үүрэг хүлээсэн хэрэглэгчээр тодорхойлж, нийт 229 хэрэглэгчийг бүртгээд байна. Улаанбаатар хот болон орон нутагт байршилтай нийт 93 хэрэглэгчтэй уулзалт газар дээр нь зохион байгуулж үйл ажиллагаатай нь танилцсан бөгөөд үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн эрчим хүч хэмнэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, удирдлагын түвшинд нэгдсэн ойлголттой болоход нийт ажилтан албан хаагчдыг сургалт, мэдээлэл, мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангасан нь үр дүнтэй боллоо. Мөн үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн нэгдсэн зөвлөгөөнийг 2019 оны 11 дүгээр сард

зохион байгуулсан бөгөөд 152 байгууллагын 200 төлөөлөгч оролцон мэдээлэл авч, харилцан туршлага солилцов. Тус зөвлөгөөний үеэр аудитын байгууллагууд, эрчим хүчний үр ашигтай тоног төхөөрөмж борлуулдаг, үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын үзэсгэлэнг зохион байгуулав.



- Эрчим хүчний зохицуулах хороо, БНХАУ-ын Стандартын үндэсний хүрээлэнгийн хооронд бүх талаар харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх хүрээнд 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн дагуу ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж 2 талын уулзалтыг зохион байгууллаа.
- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дэмжсэн жишиг төслүүдийг хэрэгжүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлж шинэ түвшинд гаргах чиглэлээр 4 жилийн хугацаатай хамтран

ажиллах санамж бичгийг БНХАУ-ын Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний төвтэй 2019 оны 9-р сарын 25-ны өдөр байгуулж, санамж бичгийн мөрөөр холбогдох уулзалтыг зохион байгуулж энэ хүрээнд хамтарсан ЭСКО төслийг “УБЦТС” ТӨХК-д хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

- ISO 50001:2018 шинэчилсэн стандартыг Стандартчилал, хэмжил зүйн газрын дэргэдэх Эрчим хүчний техникийн хороо, менежментийн хороогоор тус тус хэлэлцүүлэн үндэсний стандарт болгон батлуулав.
- “Эм Си Эс интернейшнл” ХХК, “ТЭСО” ХХК-иуд ISO 50001 стандартыг өөрийн байгууллагад бүрэн

нэвтрүүлж эрх бүхий байгууллагаас магадлан итгэмжлэл авав.

- Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлийн гишүүдэд болон орон нутгийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын төлөөллүүдэд хэрэглэгчдийн дулааны хэмжүүрийн тарифыг тооцоолох аргачлалын талаар 3 удаагийн бүсчилсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа.
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимтай хамтран 2019 оны 5 дугаар сард ОХУ-ын Иркутск хотод зохион байгуулдсан “Эрчим хүч хэмнэлтийн үр ашиг” үзэсгэлэнд үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн төлөөлөлтэй хамтран оролцов.

Дөрөв. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд болон Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний системд “Нэг худалдан авагч”-тай зах зээлийн загварыг нэвтрүүлэх, төлбөр тооцооны шуурхай байдлыг хангах зорилтын хүрээнд;

- Дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын хүрээнд нэвтрүүлэх “Дулааны нэг худалдан авагчтай загвар”-ын талаар холбогдох саналыг боловсруулж Эрчим хүчний сайдын 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 251 дүгээр тушаалаар “Улаанбаатар хотын Дулааны нэг худалдан авагчтай загвар”-ыг батлуулав.
- “Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлж буй ТЗЭ-дийн хооронд дулааны эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалыг зохицуулах аж

ахуйн харилцааны дүрэм”-ийг боловсруулан Хорооны хурлаар хэлэлцэн батлав.

- “ББЭХС” ТӨХК болон “АУЭХС” ТӨХК-ийн хүрээнд “Нэг худалдан авагчтай загвар”-ын зарчмыг нэвтрүүлэхтэй холбогдуулан судалгаа хийж уулзалт зохион байгуулан санал солилцсон бөгөөд “Нэг худалдан авагчтай загвар”-ыг эдгээр компаниудын цахилгаан үйлдвэрлэх, түгээх/хангах охин компаниудын хүрээнд мөрдөх тул толгой компаниудын шийдвэрээр загвар, мөнгөний урсгалыг батлан хэрэгжүүлэхээр болсон юм.

Тав. Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн чадавхийг бэхжүүлэх; Хорооны тусгай зөвшөөрөл, үнэ тарифын зохицуулалтын болон эрчим хүч хэмнэлтийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулах, үнэлж дүгнэх зорилтын хүрээнд;

- Эрчим хүчний хангамжийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны бодит өртөг зардал, индексжүүлэлтийн үндсэн хүчин зүйлс болох макро эдийн засгийн үзүүлэлтийн бодит өөрчлөлт, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдээс нийлүүлж буй цахилгааны өсөлт, хэрэглэгчийн төлбөрийн чадавх, нийгмийн бусад хүчин зүйлсийн талаар холбогдох судалгааг хийсний үндсэн дээр хэрэглэгчдэд

борлуулах цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифт үе шаттайгаар зохицуулалт хийсний үр дүнд эрчим хүчний салбарт шинээр 104.7 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэх боломжийг хангасан.

- Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрчим хүчний үр ашиг 3+” төслийн хүрээнд цахилгааны жижиглэнгийн тарифын



бүтэц тодорхойлох судалгааны ажлыг хийж, тайлан боловсруулж гаргав.

- Хорооноос зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд 2019 оны 4-р сард Өвөрхангай аймгийн зохицуулах зөвлөлөөс олгосон дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч 19 аж ахуйн нэгжийн, 5-р сард Завхан аймгийн зохицуулах зөвлөлөөс олгосон дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч 31 аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын биелэлтийг газар дээр нь шалгаж, шаардлагатай зөвлөмжийг өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллалаа.
- Өнгөрсөн 2019 онд хэрэгжүүлсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар

илэрсэн зөрчлүүдийг нэгтгэн зөрчлийн санд баяжилт хийж, эрсдлээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэлээр Нийслэлийн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч 62 компани, орон нутгийн дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч 25 компани, нийт 87 компани, аж ахуйн нэгжид албан бичгээр мэдэгдэл хүргүүлэв.

- Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэгч "Клин Энержи" ХХК, "Клин Энержи Ази" ХХК-иудын тусгай зөвшөөрлийн болон үйлдвэрлэн нийлүүлэх цахилгааны тарифын зохицуулалтад, "Соларповер интернейшнл" ХХК, "Эвридэй ферм" ХХК-иудын үйлдвэрлэн нийлүүлэх цахилгааны тарифын зохицуулалтад тус тус дотоод аудит хийж, зөвлөмж өгч ажиллав.
- Эрчим хүчний салбарын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулж, ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газартай хамтран тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын ерөнхий инженер, холбогдох инженер, техникийн ажилтнууд, ЭХЗХ-ны мэргэжилтнүүд зэрэг 76 компани, байгууллагын 120 ажилтан оролцсон сургалт зохион байгуулсан.

Зургаа. Төвийн бүсийн цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хангах үйл ажиллагаанд өрсөлдөөн нэвтрүүлэх нөхцөл, боломжийг судалж хэрэгжүүлж эхлэх;

- Төвийн бүсийн түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хангах үйл ажиллагааны үр ашиг, үйлчилгээний чанарыг шинэлэг менежмент, өрсөлдөөн нэвтрүүлэх замаар сайжруулах чиглэлд Герман, Сингапур, Шинэ Зеланд болон бусад олон улсын сайн туршлагаас судалж төрийн өмчит түгээх компаниудын хангах үйл ажиллагааг өрсөлдөөний үндсэн дээр Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь заалтын дагуу гэрээний дагуу гүйцэтгүүлэх санал боловсрууллаа. Судалгааны хүрээнд хангах үйл ажиллагааны өнгөрсөн жилүүдийн зардалд дүн шинжилгээ хийж, хангах үйл ажиллагааны зах зээлийн хэмжээ, гэрээгээр гүйцэтгүүлэх цар хүрээ, зорилт, гэрээний нөхцөл, гэрээг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд мөн гэрээний хугацаа дууссаны дараа авах шилжилтийн арга хэмжээний төлөвлөгөө зэрэг чиглэлүүдээр судалгааг хийгээд байна.
- Монгол улсын эрчим хүчний зах зээлийн загварыг боловсронгуй болгох талаар

Дэлхийн банктай хамтран судалгааны төслийг хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд салбарт ашиглагдаж буй орлого хуваарилах тэг үлдэгдэлтэй дансны зарчим, төрийн өмчит компаниудын хоорондын арилжааны үйл ажиллагааны хариуцлага, урамшуулалт зохицуулалтыг нэвтрүүлэх арга хэлбэр зэрэг тодорхой ажлуудыг салбарын холбогдох байгууллагуудтай хамтран хийж байна.



ДОТООД АУДИТ

Дотоод аудитын чиглэлээр 2019 онд дараах үйл ажиллагаа явууллаа.

- Хорооны бүтцийн нэгжүүдийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэн боловсруулж эрсдэлд суурилсан, Хорооны аудитын жилийн ажлын төлөвлөгөөг Хорооны хурлаар батлуулж хэрэгжүүлж ажиллалаа.
- Сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч 4 компанийн тусгай зөвшөөрлийн болон үйлдвэрлэн нийлүүлэх цахилгааны тарифын зохицуулалтад дотоод аудит хийж зөвлөмжийг холбогдох нэгж, байгууллагуудад өгөв.
- Хорооны 2019 оны зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд улирал тутам аудит хийж холбогдох дүгнэлт, зөвлөмжийг өгч ажилласан ба 2018 онд Хорооны хурлын үеэр Зохицуулагчдаас Ажлын албанд өгсөн 52 үүрэг, даалгаврын биелэлтэд аудит хийж дүгнэлт өгөв.
- Хорооны нийт ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмаар хүлээсэн үүргийг бүтцийн нэгжүүдийн ажил үүрэг, ажлын байрны тодорхойлолтод бүрэн тусгасан эсэхэд дүн шинжилгээ хийж холбогдох дүгнэлт зөвлөмжийг гаргасан.
- Хорооны санхүүгийн үйл ажиллагаа, 2019 оны зардлын төсвийн гүйцэтгэлд дотоод аудит хийж зөвлөмж өгөн санхүүгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллав.
- Үндэсний аудитын газраас 2016 онд эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд, 2017 онд эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтад тус тус хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
- Сангийн яам, Эрчим хүчний яам, Нийслэлийн аудитын газар, Дотоод аудиторчуудын олон улсын институт (IIA)-ийн Монгол дахь салбар зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Эрчим хүчний зохицуулах хороо нь салбарын үр ашгийг дээшлүүлэх, найдвартай ажиллагааг хангах, эрчим хүчний хангамжийн чанарыг дээшлүүлэхэд өөрийн орны онцлогт тохирсон зохицуулалтыг бий болгох зорилгоор 150 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нөхцөл, шаардлагын биелэлтийг "E-License" цахим системээр авч дүгнэн 2019 онд мөрдөж ажиллах зорилтыг тогтоолоо. Хорооны дүгнэлтээр 2018 онд нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 41.2 хувь нь хангалттай болон хангалттай сайн, 34.9 хувь нь дунд, 23.8 хувь нь хангалтгүй үнэлгээтэй дүгнэгдсэн байна. Хангалтгүй үнэлгээ авсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дийлэнх хувь нь эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигчид байна.

Тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын 2019 оны зорилтуудыг шинэчлэн тогтоосон нь дараах үндсэн ач холбогдолтой болно. Үүнд:

- Хэрэглэгчдийг тогтвортой үнэ өртөг бүхий чанарын шаардлага хангасан, эрчим хүчээр хангах, хэрэглэгчдийн тав тухтай амьдарч ажиллах орчныг бүрдүүлэх;
- Ухаалаг сүлжээ, технологийн шийдэл бүхий техникийн шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлэх;
- Компанийн санхүү, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, зардлын өсөлтийг бууруулах;
- Эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу үр ашгийг сайжруулах;



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОЛТ, СУНГАЛТ

Эрчим хүчний зохицуулах хороо нь 2019 оны байдлаар нийт 198 хуулийн этгээдэд 11 нэр төрлийн 376 тусгай зөвшөөрөл олгосон ба тэдгээрийн

үйл ажиллагааг эрчим хүчний талаарх хууль тогтоомжийн дагуу зохицуулж байна.


Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Үйл ажиллагаа явуулж байгаа ТЗ	Шинээр барилга байгууламж барих ТЗ	Нийт
1	Цахилгаан үйлдвэрлэх	23		
2	Дулаан үйлдвэрлэх	27		
3	Эрчим хүчний барилга байгууламж барих		64	
4	Цахилгаан түгээх	27		
5	Цахилгаанаар зохицуулалттай хангах	28		
6	Дулаан түгээх	95		
7	Дулаанаар зохицуулалттай хангах	96		
8	Цахилгаан импорт, экспорт	9		
9	Цахилгаан дамжуулах	3		
10	Диспетчерийн зохицуулалт хийх	1		
11	Цахилгаанаар зохицуулалтгүй хангах	1		
	Олгосон тусгай зөвшөөрөл	310	64	374
	Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд	140	58	198

2019 онд эрчим хүчний үйл ажиллагаа эрхэлж буй 27 аж ахуйн нэгж, байгууллагын 51 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 22 аж ахуй нэгж, байгууллагад 34 тусгай зөвшөөрлийг шинээр олгосон.

График 3

Тусгай зөвшөөрөл олголт, сунгалт



Хүснэгт 2. Тусгай зөвшөөрлийн төрөл

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Олгосон ТЗ, тоо	Сунгасан ТЗ, тоо	Дүн
1	Уламжлалт	1	3	4
	Эрчим хүчний барилга байгууламж барих	5	1	6
	Шугам сүлжээ, дэд станц барих	2		2
2	Уламжлалт			
	Цахилгаан үйлдвэрлэх	3		3
3	Дулаан үйлдвэрлэх	2	6	8
4	Цахилгаан түгээх	1	5	6
5	Цахилгаанаар зохицуулалттай хангах	1	5	6
6	Дулаан түгээх	9	14	23
7	Дулаанаар зохицуулалттай хангах	9	14	23
8	Цахилгаан импортлох, экспортлох	1	2	3
9	Цахилгаан дамжуулах		1	1
10	Цахилгаанаар зохицуулалтгүй хангах		1	1
	Дүн	34	52	86

2019 онд шинээр олгосон тусгай зөвшөөрлийн 28 буюу 53.8 хувь нь дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүд байна.

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСГҮҮР

Эрчим хүчний салбарт 2019 онд шинээр “И Эс Би солар энерги” ХХК-ийн 10 МВт-ын “Сүмбэр” нарны цахилгаан станц, “Тэнүүн гэрэл констракшн” ХХК-ийн 15 МВт-ын “Хөшигт” нарны цахилгаан станц баригдаж ашиглалтад орлоо. Ингэснээр эрчим хүчний системд 3 салхин цахилгаан станц, 5 нарны цахилгаан станц, 4 усан цахилгаан станц тус тус цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байна.

Улсын хэмжээнд цахилгаан үйлдвэрлэх нийт суурилагдсан хүч чадал 1334.5 МВт болсон бөгөөд үүний дотор сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрүүдийн нийлбэр хүчин чадал 241.4 МВт буюу 18.1 хувийг эзэлж байна.

СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ БАРИХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААР

Сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүр барьж байгуулах нийт 5 тусгай зөвшөөрлийг 2019 онд олгосон. Үүнд:

- “Усны эрчим” ХХК-д 18 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барих;

- “Жесика энерги” ХХК-д 10 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц барих;

- “Эрдэнэс пауэр” ХХК-д 45 МВт-ын хүчин чадалтай ус хуримтлуурын цахилгаан станц барих;

- “Три Эс солюшн” ХХК-д 15.4 МВт-ын хүчин чадалтай хатуу хог хаягдлаар эрчим хүч үйлдвэрлэх цахилгаан станц барих;
- “Мөнх энерги сторажи” ХХК-д 5 МВт-ын хүчин чадалтай эрчим хүчний хуримтлуурын систем барих;

Мөн “Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилээр сунгав.

2019 оны байдлаар нийт 1530.2 МВт чадал бүхий дараах сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжийг барих тусгай зөвшөөрөл эзэмшигчид байна. Үүнд:

- 450.4 МВт-ын нийлбэр чадал бүхий 4 салхин цахилгаан станц,

- 687 МВт-ын нийлбэр чадал бүхий 26 нарны цахилгаан станц,
- 145.4 МВт-ын нийлбэр чадал бүхий 4 усан цахилгаан станц,
- 145 МВт-ын нийлбэр чадал бүхий ус хуримтлуурын 2 станц,
- 47.4 МВт-ын нийлбэр чадал бүхий биомассын 2 станц,
- 55 МВт-ын нийлбэр чадал бүхий эрчим хүч хуримтлуурын 2 станц тус тус байна.

Дээрхи 40 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 22 нь “Диспетчерийн үндэсний төв” ХХК-тай, 2 нь “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-тай цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээг байгуулсан байна.

График 4

Үйлдвэрлэх хүчин чадлын бүтэц (МВт)



График 5

СЭХ-ний үйлдвэрлэх хүчин чадлын бүтэц (МВт)



2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР



Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд мэргэжлийн хяналт шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.

Эрчим хүчний зохицуулах хорооны дарга, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагчийн удирдамжаар 2019 онд төлөвлөгөөт 5, төлөвлөгөөт бус 2, гүйцэтгэлийн 2 нийт 9 хяналт шалгалт хийж, шалгалтаар нийт 54 зөрчил илрүүлэн, илэрсэн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хорооны 5 тогтоолоор 38 үүрэг даалгавар, Эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн 4 албан шаардлагаар 36 үүрэг даалгавар, 10 зөвлөмжийг хугацаатай өгч биелэлтэд нь хяналт тавьж ажиллалаа.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх" ХХК, "Хөвсгөл эрчим хүч" ХХК, "Хөвсгөл дулааны станц" ТӨХК, "Ган-Илч" ХХК-иудын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилт, 2018 оны зорилтын биелэлтэд хяналт шалгалт хийлээ.

Нийслэлийн 6 дүүрэг, Төв аймгийн 16 сум, суурин газар, Баянхонгор аймгийн 12 сум, Хөвсгөл аймгийн 15 сумын нутаг дэвсгэрийн нийт 417.1 мянган хэрэглэгчийг цахилгааны эрчим хүчээр ханган ажиллаж байгаа "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх" ХХК, "Хөвсгөл эрчим хүч" ХХК-иудын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд мэргэжлийн багаар хяналт шалгалт хийж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

1. Төвийн бүсийн хэрэглэгчдэд борлуулах цахилгаан эрчим хүчний тарифын мөрдөлтийг шалгаж Хөвсгөл аймгийн Ханх сумын хэрэглэгчдэд 2011 оноос өнөөг хүртэл хугацаанд хүчингүй болсон үнэ тарифаар цахилгаан эрчим хүч борлуулж байсан асуудлыг илрүүлж, зөрчлийг арилгуулахаар холбогдох арга хэмжээг авлаа.
2. Хэрэглэгчдээс цахилгаан эрчим хүчний орлого цуглуулах дансны харилцааг зохицуулах зорилгоор арилжааны банкуудтай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, харилцах дансны орлого зардлын гүйлгээг шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулан Эрчим хүчний зохицуулах хорооны 2015 оны 300 дугаар тогтоолоор батлагдсан "Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-

ийн 8 дахь хэсгийн хэрэгжилтийг хангуулж "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК, "Баянхонгор эрчим хүч цахилгаан түгээх" ХХК, "Хөвсгөл эрчим хүч" ХХК-иудын арилжааны банкуудтай байгуулсан гэрээг шинэчлүүлж гэрээг Эрчим хүчний зохицуулах хороо бүртгэн авлаа.

3. Хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг хүлээн авч, бүртгэх, шийдвэрлэх, хяналт тавих зэрэг асуудлуудыг газар дээр нь шалгаж Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авлаа.
4. Их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээний ажлуудыг өөр өөр аргачлалаар төлөвлөдөг, тодотголыг бодит төсвийн тооцоонд үндэслэн хийдэггүй зэргээс шалтгаалан шаардагдах хөрөнгийн хэмжээ өндөр гарч улмаар зайлшгүй хийх шаардлагатай засварын ажлууд орхигдох нөхцөл үүсч байгаад дүгнэлт хийж батлагдсан эх үүсвэрт багтаан бодитоор төлөвлөн ажиллах үүрэг даалгавар өгч ажиллав.

Түүнчлэн Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 259 аж ахуйн нэгж, байгууллага, 1127 айл өрх, Дундговь аймгийн 7 сумдын 115 аж ахуйн нэгж байгууллага, 775 айл өрхийг дулааны эрчим хүчээр хангаж байгаа "Хөвсгөл дулааны станц" ТӨХК, "Ган-илч" ХХК-иудын тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хэрэгжилтийг шалгаж эрх бүхий байгууллагаар батлагдаагүй тарифаар хэрэглэгчдэд дулаан борлуулсан, хэрэгцээний халуун ус халаасан дулааны төлбөр авсан, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төсвийн зарим байгууллагуудтай шинэчилсэн тарифаар дулааны эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ байгуулаагүй зэрэг зөрчлүүдийг илрүүлж Эрчим хүчний тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 дахь заалтын хэрэгжилтийг нэн тэргүүнд ханган ажиллах шаардлага тавьж Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өглөө.

Зөвлөн туслах үйлчилгээ: Өвөрхангай, Завхан аймгуудын эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч 51 компанид

тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зорилтын биелэлтийн тайлан мэдээ бэлтгэх, тарифын санал тооцоо боловсруулах, хэрэглэгчийн өргөдөл

гомдлыг хүлээн авч шийдвэрлэх чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж зөвлөмж өгч ажиллав.



Тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүй зарим компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэв.

Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын зорилтын биелэлт хангалтгүй, Хорооны тогтоолоор өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлээгүй “Эх голомтын илч” ХХК, “Ажбогд инженеринг”

ХХК-иудын тусгай зөвшөөрлүүдийг Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагчийн шийдвэрээр 1-3 сарын хугацаатай түдгэлзүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэв.



Эрчим хүчний тухай хууль зөрчсөн тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ногдуулав.

Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагчийн шийдвэрээр Эрчим хүчний тухай хуулийг зөрчиж тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага биелүүлээгүй, зөрчил гаргасан “Хайспийд групп”

ХХК-д Зөрчлийн тухай хуулийн 12.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн 1.0 сая төгрөгийн шийтгэлийг ногдуулав.



Хяналт шалгалтын чанар үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор МХЕГ-тай хамтран ажиллах гэрээ байгуулав.

Эрчим хүчний зохицуулах хороо нь Эрчим хүчний тухай хуулиар эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын хувьд Эрчим хүчний салбарын мэргэжлийн хяналт шалгалтын чанар үр нөлөөг дээшлүүлэх, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор МХЕГ-тай 2017 онд байгуулсан

“Санамж бичиг”-ийн хүрээнд 2019 оны 12 дугаар сард хамтран ажиллах гэрээ байгуулж улмаар МХЕГ-ын даргын тушаалаар ЭХЗХ-нд шинээр Эрчим хүчний хяналтын улсын 8 байцаагчийн эрх олгосноос 6 байцаагч нь эрчим хүчний компани, аж ахуйн нэгжүүдийн техникийн хяналт хариуцсан албан тушаалтан байна.



Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоо нэвтрүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлж байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018-2021 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний хүрээнд дэвшүүлсэн 5 үндсэн зорилгод “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх” асуудлыг тусгасан бөгөөд тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хяналтыг сайжруулах, хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр 2018 оноос эхлэн үе шаттай арга хэмжээ авч байна.

Хорооны 2018 оны 294 дүгээр тогтоолоор “Хяналт шалгалтын журам”-ыг шинэчлэн баталж, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд Хорооны дарга бөгөөд Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагчийн баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх,

тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч хоорондын маргаан шийдвэрлэх, Хорооны тогтоолын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд эрсдэлд суурилсан мониторинг хийх, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ хийх чиглэлээр Онцгой байдлын ерөнхий газар, Санхүү, эдийн засгийн их сургуультай хамтран Эрчим хүчний зохицуулах хороо болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн холбогдох мэргэжилтнүүдийг чадавхжуулах, Эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэдлэг олгох зорилгоор сургалт зохион байгууллаа.

ҮНЭ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Эрчим хүчний салбарын найдварт ажиллагаа, санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хэрэглэгчдэд борлуулах цахилгаан, дулааны үнэ, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг 4 үе шаттайгаар индексжүүлж, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тариф, үйлчилгээний төлбөр болон эрчим хүч үйлдвэрлэхэд зориулан нүүрс нийлүүлж буй томоохон уурхайнуудын нүүрсний үнийг хянаж, зохих өөрчлөлтүүдийг оруулаад байна.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний “Нэг худалдан авагч”-тай зах зээлийн арилжаанд оролцож буй цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд цахилгаан үйлдвэрлэлийн ачааллыг болон орлогыг өсгөхөд өрсөлдөөн бий болгох, үйлдвэрлэгчдийн цахилгаан, дулааны хослон үйлдвэрлэлийг нэмэгдүүлж нэгжийн өртгийг хямдруулах, диспетчерийн зохицуулалтын тухайн агшинд системийн нийт хувьсах зардлыг хамгийн бага хэмжээнд хүргэн системийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор “Цахилгааны өрсөлдөөнт зах зээлийн дүрэм”-ийг шинэчилж, дулааны цахилгаан станцуудын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн өрсөлдүүлэх ажиллагааг уралдаант хэлбэрээр зохион байгуулан 1 кВт.ц цахилгааны тарифыг хамгийн багаар санал болгосон цахилгаан

үйлдвэрлэгч нь ялагч байх үндсэн зарчмын хүрээнд холбогдох өөрчлөлтүүдийг оруулсан.

Эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх/хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зардлыг бууруулах, эрчим хүч хэмнэх, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх хөшүүрэг, сонирхлыг бий болгох зорилгоор 10 үйлдвэр, компанитай байгуулсан “Урамшуулалт зохицуулалтын гэрээ”-ний биелэлтийг дүгнэж, нийт 3.7 тэрбум төгрөгийн урамшуулал олгох асуудлыг тарифын зохицуулалтаар шийдвэрлээд байна.

Эрчим хүчний нүүрсний уурхайнуудын нүүрсний үнийг бодит өртөг, ашгийн зохих түвшинд үе шаттайгаар хүргэж индексжүүлэх, орон нутгийн эрчим хүчний эх үүсвэрүүд зохицуулалттай үнэ бүхий нүүрсээр хангагдах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор “Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж, мөрдүүлж байна.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, шимтгэлийн дүн 2018 онд 289.1 тэрбум төгрөг байсан бол 2019 онд 335.0 тэрбум төгрөг болж нэмэгджээ.

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭ, ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Эрчим хүчний зохицуулах хороо нь эрчим хүчний хангамжийн болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны бодит өртөг зардал, индексжүүлэлтийн үндсэн хүчин зүйлс болох макро эдийн засгийн үзүүлэлтийн бодит өөрчлөлт, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрүүдээс нийлүүлж буй цахилгааны өсөлт, хэрэглэгчийн төлбөрийн чадавх, нийгмийн хүчин зүйлсийн талаар холбогдох судалгааг хийсний үндсэн дээр хэрэглэгчид борлуулах цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ тарифын зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлснээр эрчим хүчний салбарт 104.7 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэх боломжийг хангасан.

Үүнээс гадна хэрэглэгчийн тарифын зохицуулалтын чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Аймаг, нийслэлийн төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд үйл ажиллагаа явуулж

буй дулааны станцуудын санхүү, эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулах, хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифыг өртөгт нь ойртуулах зорилгоор Улаанбаатар хотын Багануур, Налайх дүүрэг, Хэнтий аймгийн Батноров сумын Бэрх тосгон, Увс аймгийн Улаангом сум, Дархан-Уул аймгийн Шарын гол сум, Дундговь аймгийн Сайнцагаан, Гурвансайхан, Говь-Угтаал, Өлзийт, Цагаандэлгэр, Дэлгэрцогт, Сайхан-Овоо сум, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Сайхан, Цагааннуур, Алтанбулаг сум, Ерөө сумын Бугант тосгоны хэрэглэгчдэд борлуулах дулааны тарифт буюу Нийслэлийн болон эдгээр аймгуудын дулаан үйлдвэрлэх, түгээх/хангах 9 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тарифт өөрчлөлт оруулснаар борлуулалтын орлогыг 4,688.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүллээ.

- Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах

бүсийн гэр хорооллын 2 тарифт тоолууртай айл өрхөд борлуулах цахилгааны орой, шөнийн хэрэглээний тарифыг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд, мөн оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 100 хувиар, аймгийн төвүүд болон 10,000-аас дээш хүн амтай сум суурин газрын гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн хэрэглээний тарифыг мөн хугацаанд 50 хувиар хөнгөлсөн бөгөөд 2019 оны байдлаар 12.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг гэр хорооллын айл өрхүүдэд үзүүлээд байна.

- Монгол Улсын Засгийн газрын “Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 324 дүгээр тогтоолын дагуу цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон, цагийн ялгаварт тарифт тоолууртай өвлийн хүлэмжийн аж ахуйн шөнийн цагт хэрэглэсэн /шөнийн 22.00 цагаас өглөөний 6.00 цаг хүртэл/ цахилгааны тариф болон дэмжих тарифыг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд 100 хувиар хөнгөлөлт үзүүлэх шийдвэрийг гарган 2019, 2020 онд шаардлагатай санхүүжилтийн тооцоо судалгааг хийж, улсын төсөвт тусгах асуудлыг хариуцан ажилласан.
- Нийслэл болон аймгуудын төв, 10,000-аас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын айл өрхийн орой, шөнийн цахилгааны хэрэглээний тарифын хөнгөлөлтөөс үүсэх 12.7 тэрбум

төгрөгийн санхүүгийн дутагдлыг Улсын төсвийн санхүүжилтээр шийдвэрлүүлэв.

- Цахилгааны борлуулалтын дундаж үнэ 2018 оны гүйцэтгэлээр 151.26 төг/кВт.ц байсан бол 2019 онд 168.20 төг/кВт.ц болж нэмэгдлээ. Айл өрхөд борлуулах цахилгааны тариф бодит өртгөөс доогуур түвшинд буюу нэгж кВт.ц тутамд 44.72 төгрөгийн хөнгөлөлтийг айл өрхүүд авч байна.
- Энгийн тоолууртай айл өрхөд борлуулах цахилгаан эрчим хүчний тариф 2019 онд дунджаар 150 кВт.ц хүртэлх хэрэглээнд 122.08 төг/кВт.ц, 151 кВт.ц-аас дээших хэрэглээнд 140.08 төг/кВт.ц байсан бөгөөд цахилгааны нэгжийн өртгөөс 20.4-30.6 хувиар доогуур, мөн цагийн ялгаварт тарифт тоолууртай айл өрхөд борлуулах цахилгаан эрчим хүчний тариф өдрийн хэрэглээнд /өглөөний 06.00 цагаас шөнийн 21.00 цаг хүртэл/ 140.18 төг/кВт.ц, оройн шөнийн хэрэглээнд /оройн 21.00 цагаас шөнийн 06.00 цаг хүртэл/ 112.98 төг/кВт.ц буюу 20.3-35.8 хувиар доогуур түвшинд байна. Эрчим хүчний салбарын хэмжээнд айл өрхөд борлуулсан цахилгааны тарифт 62.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлтийг хөндлөн татаасаар үзүүлсэн байна.
- Хэрэглэгчдэд ирэх ачааллыг зохистой хэмжээнд хөнгөлөх зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд шаардагдах үнэ тарифын алдагдалтай холбоотой татаасыг тооцож, Улсын төсвөөс олгох асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад танилцуулсан ба орон нутгийн 8 тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгох 17.15 тэрбум төгрөгийн татаас улсын төсөвт тусгагджээ.



Хүснэгт 3. Хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф /НӨАТ-гүй/

№	Хэрэглэгчдийн ангилал	Хэмжих нэгж	Төв, Өмнөд, (дэмжих тариф 23.79 төг/кВт.ц-ийг тусгасан)	Зүүн бүс	Алтай-Улиастайн бүс (дэмжих тариф 11.88 төг кВт.ц-ийг тусгасан)	Баруун бүс (дэмжих тариф 11.88 төг кВт.ц-ийг тусгасан)
1	2	3	4	5	6	
Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр						
1	Энгийн тоолууртай	төг/кВт.ц	179.69	155.90	163.48	163.48
2	3 тарифт тоолууртай					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	179.69	155.90	163.48	
	б. Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	299.79	276.00	283.58	
	в. Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	100.89	77.10	84.68	
Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага						
1	Энгийн тоолууртай	төг/кВт.ц	164.38	140.59	160.08	160.08
2	3 тарифт тоолууртай					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 17.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	164.38	140.59	160.08	
	б. Оройн хэрэглээ /оройн 17.00 цагаас шөнийн 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	245.68	221.89	241.38	
	в. Шөнийн хэрэглээ /шөнийн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	112.98	89.19	108.68	
3	"Цахилгаан тээвэр" ХК	төг/кВт.ц	112.98	89.19		
4	Улаанбаатар хот, аймгийн төвийн нийтийн зориулалттай зам талбайн гэрэлтүүлэг болон нийтийн зориулалттай орон сууцны орцны гэрэлтүүлэг					
	10,11,12,1,2,3 дугаар саруудад					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройны 19.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	164.38	140.59	160.08	
	б. Орой, шөнийн хэрэглээ /оройн 19.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	112.98	89.19	108.68	
	4,5,6,7,8,9 дүгээр саруудад					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройны 22.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	164.38	140.59	160.08	
	б. Орой, шөнийн хэрэглээ /оройн 22.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	112.98	89.19	108.68	
Айл өрх						
1	2 тарифт тоолууртай					
	а. Өдрийн хэрэглээ /өглөөний 06.00 цагаас оройн 21.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	140.18	116.39	135.88	
	б. Оройн хэрэглээ /оройн 21.00 цагаас өглөөний 06.00 цаг хүртэл/	төг/кВт.ц	112.98	89.19	108.68	
2	Энгийн тоолууртай					
	а. Сарын нийт хэрэглээний 150 кВт.ц хүртэл хэрэглээг	төг/кВт.ц	134.28	110.49	129.98	
	б. Сарын нийт хэрэглээний 151 кВт.ц болон түүнээс дээш хэрэглээг	төг/кВт.ц	154.08	130.29	149.78	122.68
3	Ахуйн тоолуургүй хэрэглэгчдийн төлбөр тооцох сарын дундаж хэрэглээ					
	а. Орон сууц	кВт.ц	350.0	350.0	350.0	350.0
	б. Гэр хороолол	кВт.ц				
4	Эмзэг бүлгийн хэрэглэгчдийн тариф					
	а. УБ -100 кВт.ц, Дархан, Эрдэнэт -75 кВт.ц, Бусад -50 кВт.ц хүртэл	төг/кВт.ц	84.08	60.29	72.17	72.17
	б. УБ -101 кВт.ц, Дархан, Эрдэнэт -76 кВт.ц, Бусад -51 кВт.ц-аас дээш	төг/кВт.ц	105.18	81.39	93.27	93.27

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

Цахилгаан, дулааны үнэ болон хэрэглээний өөрчлөлт, эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалтын хэмжээнд үндэслэн жилийн эхэнд болон тухай бүр тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн буюу цахилгаан, дулааны үйлдвэрлэгчийн үнэ, дамжуулах, түгээх, хангах болон диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний төлбөр, цахилгаан, дулаан худалдан авах тарифуудыг тогтоож, шаардлагатай тарифын зохицуулалтыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санал, тооцоололд үндэслэн тухай бүрд авч хэрэгжүүлээ.

Өнгөрсөн 2019 онд тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад хөрөнгийн эх үүсвэртэй холбоотойгоор 221 удаагийн, хэрэглэгчийн тарифын өөрчлөлттэй холбоотойгоор 47 удаагийн, нийт 268 удаагийн тарифын зохицуулалт хийж, эдгээр зохицуулалтын хүрээнд эрчим хүчний эх үүсвэрүүдэд 40.8 тэрбум төгрөг, цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ, диспетчерийн үндэсний төвд 35.0 тэрбум төгрөг, дулааны сүлжээ болон орон сууц, нийтийн аж ахуйн компаниудад 7.3 тэрбум төгрөг, нийт 83.1 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэрийг шийдвэрлэж, санхүүгийн чадавхыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. Үүнд цахилгаан, дулааны тариф тооцох аргачлал болон тарифын хянан шалгах журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 2019 оны борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд 65.0 тэрбум төгрөгийн


хөрөнгийн эх үүсвэрийг, мөн эрчим хүчний тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний чанарыг дээшлүүлэх, "Оюутолгой" ХХК-ийг нэгдсэн сүлжээнд холбох зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын тарифт хөрөнгө оруулалтын өгөөжөөр 18.0 тэрбум төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг тусгах тарифын зохицуулалт хийсэн болно.

Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл эзэмшигч бие даасан эрчим хүчний 1 үйлдвэрлэгч буюу нүүрсээр ажиллах цахилгаан станцын цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний гарааны үнийг баталгаажуулж, 2 усан цахилгаан станц, 1 ус хуримтлуурын цахилгаан станцын үйлдвэрлэх цахилгааны үнэ, тарифыг Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд заасан хязгаарын хүрээнд тогтоосон байна.

Эрчим хүчний зориулалттай нүүрс олборлож буй уурхайнууд болох "Багануур" ХК, "Шивээ овоо" ХК, "Шарынгол" ХК-иас ирүүлсэн нүүрсний үнийн саналыг Эрчим хүчний тухай хууль, "Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлал"-ын дагуу тооцож, эдгээр 3 уурхайн нүүрсний үнийг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 1 тонн тутамд 2000.0 төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн, нийт 7.1 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг тарифын зохицуулалтаар шийдвэрлэсэн.

График 6


Төв, Өмнөд бүсийн уул уурхайн хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тариф, төг/кВт.ц



/Энгийн тоолууртай/ Уул уурхай
Дэмжих тариф

График 7


Төв, Өмнөд бүсийн ҮААНБ-д борлуулах цахилгааны тариф, төг/кВт.ц



/Энгийн тоолууртай/ Бусад ҮААНБ
Дэмжих тариф

График 8

Айл өрхөд борлуулах цахилгааны тариф, төг/кВт.ц /Сэргээгдэх эрчим хүчний тариф тусгасан/




/Энгийн тоолууртай/

Дэмжих тариф
151 кВт.ц-аас дээш хэрэглээтэй айл өрх
150 кВт.ц хүртэл хэрэглээтэй айл өрх

График 9

Айл өрхөд борлуулах цахилгааны тариф, төг/кВт.ц /Сэргээгдэх эрчим хүчний тариф тусгасан/




/Тарифт тоолууртай/

Дэмжих тариф
Шөнийн хэрэглээ /21:00-06:00 цаг/
Өдрийн хэрэглээ /06:00-21:00 цаг/

График 10

Баруун бүсийн цахилгааны тариф, төг/кВт.ц /Сэргээгдэх эрчим хүчний тариф тусгасан/



/Энгийн тоолууртай/

2019
2018
2017
2016
2015
2014
2001

График 11


Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын орон сууцны халаалт, төг/м²



/Тарифт тоолууртай/

График 12


Орон сууцны хэрэгцээний халуун ус халаасан дулаан, төг/хүн



Халаалтын бус улиралд
Халаалтын улиралд

График 13

ААНБ-ын халаалт, төг/м³



Эрдэнэт
Дархан
Улаанбаатар

Хүснэгт 4. Хэрэглэгчдэд борлуулах дулааны тариф /НӨАТ-гүй/

№	Нэр	Айл өрхийн халаалт				Хэрэгцээний халуун ус халаасан дулаан			Хэмжүүрээр тооцох дулаан, төг/ГДж						
		Халаалт, төг/м²	Ахуйн хэрэглэгчийн дулааны үйлчилгээний тариф, төг/сар			Хал. улирал Хүн, төг/хүн	Хал. бус улирал Усны зарцуулалт, төг/м³	Технологийн уур							
			40 м²	40-80 м²	81 м²-аас дээш			ААНБ төг/м³	Айл өрх	ААНБ	8-13 ата			20 ата	
											"1,000.0 Гкал хүртэл"	"1,000.0 Гкал -аас дээш"			
1	Улаанбаатар	506	3,300	5,500	11,000	472	1,870	2,806	1,632	3,421	7,277		5,397		
2	Дархан	506	3,300	5,500	11,000	470	1,870	2,806	2,500	3,421	6,419	6,061	5,360	6,569	
3	Эрдэнэт	506	3,300	5,500	11,000	504	1,870	2,806	2,500	3,421	7,854		8,533		
4	Дорнод	506	3,300	5,500	11,000	769	1,870	2,806	-	3,421	6,698	-	-	-	-
5	Даланзадгад	506	3,300	5,500	11,000	961	1,870	2,806	-	-	20,843	-	-	-	-
6	Налайх	600	3,000	5,000	10,000	860 - 1,290	2,875	4,025	5,000	-	25,813	-	-	-	-
7	Багануур	660	3,300	5,500	11,000	1,145 - 1,239	3,163	4,428	1,632	8,711	18,310 - 19,795	-	-	-	-

ЦАХИЛГААНЫ СПОТ ЗАХ ЗЭЭЛ


Спот зах зээл нь цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлийн диспетчерийн графикийн төлөвлөлт ба бодит нийлүүлэлтийн зөрүүн дээр үүсгэсэн зах зээл юм.

Спот зах зээлийг ажиллуулснаар дулааны цахилгаан станцууд диспетчерийн графикийн зөрчил, доголдол гаргахгүй байх, гаргасан тохиолдолд зах зээлийн зарчмаар эдийн засгийн хариуцлага хүлээх бөгөөд энэхүү арилжаанд оролцогч хоёр үйлдвэрлэгчийн энергийн тарифын зөрүүгээр худалдах арилжаа хийгддэг болно.

Спот зах зээл дээр 2019 онд 293.5 сая төгрөгийн өртөг бүхий 6,005.6 мянган кВт.ц цахилгаан эрчим хүчний арилжаа үйлдвэрлэгчдийн хооронд хийгдсэн байна. Тайлант хугацаанд Спот зах зээл дээр "ДЦС-4" ТӨХК 1.57 сая төгрөгийн, "ДЦС-3" ТӨХК 0.3 сая төгрөгийн, "ЭДЦС" ТӨХК 0.08 сая төгрөгийн ашигтай, "ДЦС-2" ТӨХК 0.07 сая төгрөгийн, "ДДЦС" ТӨХК 0.16 сая төгрөгийн, "ЭУДЦС" ТӨХК 0.06 сая төгрөгийн, Ухаахудагийн ЦС 0.83 сая төгрөгийн, "ДзДЦС" ТӨХК 0.78 сая төгрөгийн хариуцлага хүлээж ажилласан байна. Спот зах зээл дээрх өглөг, авлага оны эхний үлдэгдлээс 1.8 сая төгрөгөөр буурсан байна.



10 Эрчим хүчний системийн тогтворжилтыг хянах, түүнийг хангахад чиглэсэн WAMS системийг салбартаа нэвтрүүлэв.



9 Эрдэнэтийн дулааны цахилгаан станцын өргөтгөлийн ажлыг эхлүүллээ. Өргөтгөл хийгдсэнээр станцын суурилагдсан хүчин чадлыг хоёр дахин нэмэгдүүлэх юм.



8 Сэргээгдэх эрчим хүчний хүрээнд Сүмбэрийн 10 МВт-ын, Бөхөгийн 15 МВт-ын нарны станцууд баригдаж ашиглалтад оров.





7 БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 330 кВ-ын Улаанбаатар-Мандалговийн цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьж ашиглалтад оруулав.



6 Европын сэргээн босголт, хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр ДДЦС ТӨХК-ийн хүчин чадлыг 35 МВт-аар өргөтгөх ажлыг дуусган ашиглалтад хүлээн авлаа.



ЭРЧ
ХҮЧНИЙ С
20
ОНЫ О
10 АХ





ИМ АЛБАРЫН 19 НЦЛОХ ЖИЛ



Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах зорилгоор нэг жилийн хугацаанд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг барьж ашиглалтад оруулав. Тус үйлдвэр нь өнөөдрийн байдлаар 56,608.9 тн сайжруулсан шахмал түлш, 756,881 тн түүхий эд буюу мидлингийн нөөцтэй байгаа бөгөөд хоногт 2096 орчим тн сайжруулсан шахмал түлшийг үйлдвэрлэж түгээн, хэрэглэгчдэд борлуулж байна.

1



Нийслэлийн 42000 айл өрхөд 4 квт-ын цахилгаан халаагуур ашиглах боломжийг бий болгож өгөв. Энэ нь Нийслэлийн агаарын бохирдлыг эрс бууруулан Улаанбаатарын оршин суугчдыг аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бий болгож өгч байна.

2



Ховд аймагт Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын усан цахилгаан станц, Нийслэлд 100 МВт-ын батарей хуримтлуурын станц барьж байгуулах ажлуудын хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэлээ.

3



Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулж, УИХ-аар батлуулснаар тусгай зөвшөөрлийн замбараагүй олголтод цэг тавьж, хэрэглэгчдэд очих үнийн дарамтыг багасгах хууль, эрх зүйн боломжийг нээж өглөө.

4



ОХУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр ДЦС-4 ТӨХК-ийн турбингенераторыг шинэчлэх төслийн хүрээнд эхний ээлжийн хоёр турбингенераторыг шинэчлэн 43 МВт-аар хүчин чадлыг нь нэмэгдүүлэв.

5



НЭГ ХУДАЛДАН АВАГЧТАЙ ЗАХ ЗЭЭЛ

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгаан эрчим хүчний арилжаа “Нэг худалдан авагч”-тай зах зээлийн загварын хүрээнд хийгдэж байна. Нэг худалдан авагч нь төвийн бүсийн 5 дулааны цахилгаан станц, Ухаахудагийн цахилгаан станц, Эрдэнэт үйлдвэр дулааны цахилгаан станц, Даланзадгадын дулааны цахилгаан станц болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсгүүрүүд болох Салхит, Цэций, Сайншанд зэрэг салхин цахилгаан станц, Солар пауэр интернэйшнл, Эвридэй Ферм, Нарантээг, И Эс Би солар энерги, Тэнүүнгэрэл констракшн зэрэг нарны цахилгаан станцуудаас, мөн ОХУ-аас цахилгаан эрчим хүч импортоор худалдан авч төвийн бүсийн 18 цахилгаан түгээх компани болон “Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д борлуулдаг бөгөөд Нэг худалдан авагчийн үүргийг “Диспетчерийн үндэсний төв” ХХК хэрэгжүүлж байна.

Төвийн бүсийн хэрэглэгчдээс цуглуулсан цахилгааны орлогыг арилжааны банкуудад байршуулсан “Тэг үлдэгдэлтэй орлогын данс”-аар урьдчилан тогтоосон хувь хэмжээний дагуу үйлдвэрлэгч, дамжуулагч, түгээгч компаниудын дансанд өдөр бүр хуваарилдаг ба энэхүү хувь хэмжээг эрчим хүчний төлбөрийн мөнгөний урсгалын зохицуулалтад хамрагдагч 18 тусгай


зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөл оролцсон “Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хурал”-аар хэлэлцэн тогтоож, мөрдөж байна.

Нэг худалдан авагч нь 2019 онд 4,844.2 сая кВт.ц цахилгааныг төвийн бүсийн 5 дулааны цахилгаан станцаас, 443.2 сая кВт.ц цахилгааныг салхин цахилгаан станцуудаас, 109.1 сая кВт.ц цахилгааныг нарны цахилгаан станцуудаас, 299.2 сая кВт.ц цахилгааныг Ухаа худаг, Даланзадгад, Эрдэнэт үйлдвэрийн ДЦС-уудаас, 250.8 сая кВт.ц цахилгааныг ОХУ-аас импортоор авсан ба 5,736.1 сая кВт.ц цахилгааныг цахилгаан түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудад худалдаж, 26.5 сая кВт.ц цахилгааныг экспортолсон байна. Өмнөх оны гүйцэтгэлээс худалдан авсан цахилгааны эрчим хүч 5.27 хувиар, дундаж үнэ 14.3 хувиар, худалдсан цахилгааны эрчим хүч 5.27 хувиар, дундаж үнэ 11.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2019 оны дүнгээр цахилгаан түгээх компаниуд Нэг худалдан авагчид нийт худалдан авсан цахилгааны төлбөрийн 99.0 хувь буюу 760.4 тэрбум төгрөгийг төлж, Нэг худалдан авагч нь цахилгаан станцуудаас болон импортоор худалдан авсан цахилгаан эрчим хүчний төлбөрийн 97.3 хувийг төлж барагдуулсан байна.

График 14

Нэг худалдан авагчтай загварын орлого төвлөрүүлэлт



Түгээх, хангах ТЗЭ

Үйлдвэрлэх, дамжуулах ТЗЭ

ЦАХИЛГААНЫ ӨРСӨЛДӨӨНТ ЗАХ ЗЭЭЛ

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний цахилгааны үйлдвэрлэлт, түгээлтийн анхны төлөвлөгөөтэй харьцуулахад 2019 онд цахилгааны хэрэглээ 56.9 сая кВт.ц-аар буюу 0.9 хувиар буурчээ. Өрсөлдөөнт зах зээл дээр 2019 оны 10 дугаар сараас эхлэн эрчим хүчний тухай хуулийн 15.2.1 дэх заалтын хүрээнд өндөр өртөг бүхий импортын цахилгаан эрчим хүчийг багасгаж “Нэг худалдан авагчтай загвар”-ын алдагдлыг бууруулах зорилгоор Төвийн бүсийн хямд өртөг бүхий дулааны цахилгаан станцуудыг зах зээлд оролцуулах арга хэмжээг

хэрэгжүүлэн ажилласнаар тус зах зээл дээр 30.6 сая кВт.ц цахилгааны 1.59 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бөгөөд үүний үр дүнд импортын эрчим хүчний үнэтэй харьцуулсан дүнгээр 5.78 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан байна. Мөн Цахилгааны өрсөлдөөнт зах зээлийн дүрэмд 2019 оны 12 дугаар сард хэрэглээний өсөлтийг хангах болон өндөр өртөг бүхий импортын цахилгааныг бууруулах зорилгоор арилжаа зарлах агуулга бүхий нэмэлт өөрчлөлтийг оруулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа.

ХЭРЭГЛЭГЧИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

Хэрэглэгчдийн цахилгаан хангамжийн тасалдлыг олон улсын хэмжээнд мөрддөг индексүүдийг ашиглан тооцож байна. Үүнд

1. Системийн цахилгаан тасалдлын дундаж хугацааны индекс /SAIDI-System average interruption duration index/ нь жилд нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа;
(минут/тасарсан хэрэглэгч/жил)
2. Системийн цахилгаан тасалдлын дундаж тохиолдлын индекс /SAIFI-System average interruption frequency index/ нь жилд нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын тоо;
(тасралт/тасарсан хэрэглэгч/жил)
3. Тасарсан хэрэглэгчдийн тасалдлын дундаж хугацааны индекс /CAIDI-Customer average interruption duration index/ нь жилд тасалдалд

хамрагдсан хэрэглэгчид ногдох тасалдлын үргэлжлэх дундаж хугацаа;
(минут/тасарсан хэрэглэгч/жил)

Хэрэглэгчийн цахилгаан хангамжийн тасалдлын хэмжээг дээр дурьдсан 3 индексийг ашиглан улирал бүрээр гаргаж, дүгнэж ажиллалаа. Ингэхэд индексүүдийг цахилгаан түгээх компани бүрээр, мөн төлөвлөгөөт тасалдал, хангагчийн буруутай үйл ажиллагаа, байгалийн гамшиг, бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн буруу зэрэг шалтгаан бүрээр ангилан гаргаж байна.

Улсын хэмжээнд 2019 онд нэг хэрэглэгчид 54 цагийн тасалдал ногдож байгаа нь өмнөх оноос 8 цагаар буурчээ. Түүнчлэн нэг хэрэглэгчид ногдож буй тасалдлын тоо 9 болж өмнөх оноос 6-аар буурсан үзүүлэлттэй байна. Үүнд: Төвийн бүс, Баруун бүсийн эрчим хүчний систем, Алтай-Улиастайн эрчим хүчний системийн тасалдлын үргэлжлэх хугацаа буурсан нь нөлөөлсөн байна.

График 15. Тасалдлын индекс



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 7 дулааны цахилгаан станцын дүнгээр 2019 онд дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хувь хэмжээг өмнөх оны гүйцэтгэл 14.1 хувиас 0.4 нэгжээр бууруулж 13.62 хувьд хүргэснээр 22.4 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг хэмнэсэн байна. Үүнд "ДДЦС" ТӨХК-ийн 35 МВт-ын өргөтгөл ашиглалтад

орж станцын суурилагдсан хүчин чадал нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

Харин "ДБЭХС" ТӨХК дотоод хэрэгцээний цахилгаанаа 2019 онд 0.18 нэгжээр буюу 420 мянган кВт.ц цахилгаанаар хэтрүүлсэн байна.

График 16

ТБНС-ний дулааны цахилгаан станцуудын дотоод хэрэгцээний цахилгааны зарцуулалт (хувиар)





График 17

Дулааны цахилгаан станцуудын жишмэл түлшний хувийн зарцуулалт



ЖТХЗ цахилгаанд гр/кВтц

ЖТХЗ дулаанд кг/Гкал

Тайлбар: Эрдэнэт үйлдвэрийн ДЦС болон Даланзадгадын дулааны цахилгаан станц Төвийн


бүсийн нэгдсэн сүлжээнд 2018 оноос эхлэн зэрэгцээ ажиллаж эхэлсэн тул нэмж тооцов.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний 7 дулааны цахилгаан станцуудын дүнгээр 2019 онд цахилгаанд 322.4 гр/кВт.ц, дулаанд 179.7 кг/Гкал жишмэл түлш зарцуулсан нь өмнөх оны гүйцэтгэлээс цахилгаанд

2.4 гр/кВт.ц-аар, дулаанд 1.0 кг/Гкал-аар тус тус буурч, нийт дүнгээрээ 24.1 мянган тонн жишмэл түлш буюу 53.0 мянган тонн нүүрс бага зарцуулжээ.

График 18

ТБНС-ний цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдал



Цахилгаан түгээлтийн алдагдлыг өмнөх онтой харьцуулахад 2019 онд “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК (0.18 нэгж), “Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ХК (3.01 нэгж) бууруулжээ. Харин “Цахилгаан дамжуулах үндэсний

сүлжээ” ТӨХК, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-иудын дамжуулалт, түгээлтийн алдагдал 0.02-0.95 нэгжээр нэмэгдсэн нь нийт алдагдал буурахад сөргөөр нөлөөлжээ.

Хүснэгт 5. Дулааны цахилгаан станцуудын үндсэн тоноглолын ажиллагаа

ТЗЭ	Зуухны дугаар	Тасралтгүй ажилласан хугацаа		Турбины дугаар	Тасралтгүй ажилласан хугацаа	
		цаг	хоногоор		цаг	хоногоор
ДЦС-2 ТӨХК	К-5	2457	102	ТГ-3	4709	196
ДЦС-3 ТӨХК	К-10	3518	147	ТГ-7	3624	151
ДЦС-4 ТӨХК	К-5	3326	139	ТГ-7	3305	138
ДДЦС ТӨХК	К-4	1826	76	ТГ-4	3696	154
ЭДЦС ТӨХК	К-6	3149	131	ТГ-1	3247	135
Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	К-6	1831	76	ТГ-5	2880	120
ДэдЦС ТӨХК	К-3	1128	47	ТГ-3	1152	48
ДБЭХС ТӨХК	К-6	3288	137	ТГ-1	6072	253
MCS international ХХК	К-2	2456	102	ТГ-3	1876	78

ХЭРЭГЛЭГЧИЙН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ

Эрчим хүчний зохицуулах хороонд 2019 онд нийт 1771 хэрэглэгчийг хамаарсан 235 өргөдөл бичгээр ирсэн бөгөөд утсаар 1180, Засгийн газрын 11-11 төв, и-мэйлээр 47, биечлэн 353 хэрэглэгч хандан заавар зөвлөмж авч гомдол, хүсэлтээ шийдвэрлүүлсэн. Ирүүлсэн өргөдөл, гомдлын тоог өмнөх онтой харьцуулахад 30 өргөдлөөр буюу 34%-иар нэмэгдсэн байна. Бичгээр ирүүлсэн нийт

өргөдөл, гомдлын 38 хувь буюу 89 нь цахилгааны эрчим хүчтэй, 62 хувь буюу 146 нь дулааны эрчим хүчтэй холбоотой байсан. Нийт өргөдлийн 78 хувь буюу 183 нь өргөдөл гаргагч талд, 10 хувь буюу 24 нь тусгай зөвшөөрөл эзэмшигч талд шийдвэрлэгдэж, бусад 12 хувь буюу 28 өргөдөлд холбогдох тайлбар, мэдээллийг хүргэж ажиллав.

Эрчим хүчний зохицуулах хорооны хүлээн авч байгаа өргөдөл, гомдлын хэлбэр:



Мөн хэрэглэгчийн эрх ашиг хөндөгдсөн, шүүхээс шинжээчийн дүгнэлт гаргахыг мэдэгдсэн гомдол,

маргаанаар нийт 6 ажлын хэсэг, 4 удаа шинжээч томилогдон ажиллалаа.



График 19

Ирсэн өргөдлүүдийг хэрэглэгчийн төрлөөр нь авч үзвэл:



График 20

Өргөдөл, гомдол ирүүлсэн хэрэглэгчид, шийдвэрлэсэн байдал:



Хэрэглэгчийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад 246.8 сая төгрөгийн төлбөрийн буцаалт, хэрэглэгчдийн болон компаниуд хоорондын 1,261.2 сая төгрөгийн өр төлбөрийн тооцооллыг шалгаж маргааныг шийдвэрлэсэн.

Эрчим хүчний зохицуулах хороо нь хэрэглэгчийн тухайн оны өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж нийтийг хамарсан, зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай асуудлуудыг дараа жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж, үе шаттай арга хэмжээнүүдийг авдаг бөгөөд жил бүр тусгай зөвшөөрлүүдийн нөхцөл, шаардлагын зорилтод тусгаж хэрэгжилтийг хянан үнэлэлт дүгнэлт өгч байна. Үүний дагуу тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байсан иргэн, СӨХ, хуулийн этгээдүүдийг цэгцлэн, холбогдох арга хэмжээг жил дараалан авснаар 2019 онд нийтийг хамарсан өргөдөл, гомдол өмнөх онуудаас буурч, нийт өргөдөл, гомдлын дийлэнх хувийг орон сууцны дундын эзэмшилд хамаарах цахилгаан, дулааны шугам, тоноглолын ашиглалт, засвар үйлчилгээ,

төлбөртэй холбоотой маргаанууд эзэлж байна. Энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай уялдуулан төрийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлан таниулах нээлттэй өдөрлөгт тус оны 9-р сарын 16-27-ны өдрүүдэд оролцсон бөгөөд хэрэглэгчдэд хууль тогтоомжийн талаарх шаардлагатай мэдээллийг өгч газар дээр нь өргөдөл, гомдлыг шийдвэрлэж ажиллалаа. Мөн Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Авлигатай тэмцэх газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын зохицуулах зөвлөл, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар зэргээс зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөнүүдэд оролцож, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах талаар хийж буй ажлуудыг танилцуулах, холбогдох мэдээллийг солилцох зэргээр хамтран ажиллав.




Эрчим хүчний хэрэглэгчдийг салбарын болон зохицуулалтын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллээр хангах зорилгоор цахим мэдээллийн веб сайт хөгжүүлэх, цахим гарын авлага бий болгох зорилгын хүрээнд эрчим хүчний хэрэглэгчдэд зориулсан “Цахим лавлах систем”-ийг боловсруулж <https://info.erc.mn> домайн хаяг дээр байршуулан ашиглалтанд оруулсан болно.

Энэхүү цахим систем нь:

- Цахилгааны хэрэглэгчдэд зориулсан зөвлөмж
- Дулааны хэрэглэгчдэд зориулсан зөвлөмж
- Түгээмэл асуулт, хариулт /цахилгаан/
- Түгээмэл асуулт, хариулт /дулаан/
- Хэрэглэгчийн цахилгааны тариф

- Хэрэглэгчийн дулааны тариф
- Хууль эрх зүйн мэдээлэл
- Дүрэм, журмууд
- Санал асуулга, судалгаа
- Өргөдөл, гомдол гаргах заавар
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчид
- Эрчим хүчний хэмнэлт, үр ашиг
- Хорооны үйл ажиллагааны тайлан
- Эрчим хүчний статистик үзүүлэлтүүд

зэрэг цэсүүдтэй, бүх цэсүүдэд цаг үеийн шаардлагатай мэдээллүүдийг байршуулсан бөгөөд тухай бүрт мэдээллийг шинэчлэн оруулах боломжтой болсон.



“ДУЛААН ОРЧИН-ХЭРЭГЛЭГЧИЙН АЯ ТУХ” АЯН



Хэрэглэгчдийн ая тухтай өвөлжих нөхцөлийг бүрдүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах зорилгоор Эрчим хүчний зохицуулах хорооноос 3 дахь жилдээ “Дулаан орчин-хэрэглэгчийн ая тух” сэдэвт аяныг зохион байгуулж ажиллалаа. Аяны хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дулаан түгээх, хангах үйл ажиллагаа, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, хэрэглэгчийн санал, хүсэлтийн шийдвэрлэлт, диспетчерийн шуурхай ажиллагаа, эрх зүйн баримт бичгүүдийн бүрдэл зэргийг шалгаж аваар, саатлаас урьдчилан сэргийлэх, гарсан гэмтэл, саатлыг түргэн шуурхай устгах, засварлахад удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа.

Шалгалтаар дулаан хангамжийн чанар, ажилтнуудын харилцааны ёс зүйтэй холбоотой нийтлэг зөрчил дутагдал, өмнөх онуудаас буурсан үзүүлэлттэй байна. Харин Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 290, 292 дугаар тогтоолуудаар баталсан “Холболтын журам”, “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн хэрэгжилт хангалтгүй, зохих заалтуудыг хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд тусгаагүй, төлбөр тооцоонд бүрэн мөрдөөгүй, хөдөлмөр хамгаалал,



аюулгүй ажиллагаа, горим параметрийн хөтлөлт, мэдээ, дуудлагын бүртгэл, техник ашиглалтын паспортын бүрдэл зэрэг нь шаардлага хангахгүй байв.

Мөн аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд тухайн орон нутагтаа энэхүү аяныг зохион байгуулж сумдын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дулаан түгээх, хангах үйл ажиллагааны өдөр тутмын параметр, мэдээллүүдийг авч, газар дээр нь үзэж шалган холбогдох зөрчил дутагдлыг арилгуулан, Хороонд тухай бүр мэдээ тайланг ирүүлэн ажилласан.

Түүнчлэн дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн болон орон нутгийн өмчит 67 компанийн нийт 190 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулсан чадваржуулах сургалтыг зохион байгууллаа. Сургалтын үеэр өвлийн их ачааллын үед гэмтэл саатал, аваар осолгүй ажиллах, хэрэглэгчийг стандартын шаардлага хангасан дулааны эрчим хүчээр хангах, хэрэглэгчээс авах авлагыг бууруулах талаар арга хэмжээ авах, хэрэглэгчдэд хуулиар олгосон эрх, үүргийг сурталчлан таниулах, мэдээллээр хангахад анхаарч ажиллахыг үүрэг болгосон.

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛҮҮДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд нь Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан эрх, үүргийн хүрээнд дулаан үйлдвэрлэх 235, дулаан түгээх 227, дулаанаар зохицуулалттай хангах 231, дулаанаар зохицуулалтгүй хангах 4, цахилгаан үйлдвэрлэх 23, эрчим хүчний барилга байгууламж барих 6, нийт 722 тусгай зөвшөөрлийг нийт 276 хуулийн этгээдэд олгож, олгосон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавих, хэрэглэгчдэд борлуулах дулааны үнэ тарифыг батлан мөрдүүлэх, аймгийн засаг даргын тамгын газартай хамтран аймаг, орон нутагт өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, эрчим хүч хэмнэх хөтөлбөрийг боловсруулж батлуулан ажилласан байна.

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд нь холбогдох хууль тогтоомжид заасан чиг үүргийн хүрээнд тусгай зөвшөөрөл, үнэ тарифын зохицуулалтыг хэрэгжүүлэх, ялангуяа орон нутагт хэмжүүрээр тооцох дулааны тарифын суурь тооцооллыг хийх, түүнийг хянаж тогтоох, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад Эрчим хүчний зохицуулах хорооноос сургалт зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласаны зэрэгцээ зохицуулах зөвлөлүүдийн жилийн төсвийн гүйцэтгэлд хяналт хийж, тэдгээрт тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулж хүргүүлсэн.

Зохицуулах зөвлөлүүдийн үйл ажиллагааг сайжруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн инженер, техникийн ажилтнуудыг чадваржуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах зорилгоор зохицуулах зөвлөлийн гишүүд болон тэдгээрийн олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд 3 удаагийн бүсчилсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Үүнд:

- Төвийн бүсийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг Сэлэнгэ аймагт 2019 оны 3 дугаар сард зохион байгуулж Хөвсгөл, Орхон, Булган, Дархан-Уул,



Сэлэнгэ аймгийн зохицуулах зөвлөлүүд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч 38 компанийн нийт 120 гаруй төлөөлөл оролцсон болно. Семинарын үеэр төлөөлөгчид Сэлэнгэ аймгийн “Эл Си Би” ХХК-ийн усан халаалтын зуухны газрын үйл ажиллагаатай танилцаж дулаан хамгамжийн үйл ажиллагааны сайжруулалт, найдвартай ажиллагааг ханган ажиллах талаар харилцан туршлага солилцсон юм.

- Хангайн бүсийн нэгдсэн сургалт, семинарыг 2019 оны 4 дүгээр сард Өвөрхангай аймагт зохион байгуулж Баянхонгор, Архангай, Өвөрхангай аймгийн зохицуулах зөвлөлүүд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч 57 компанийн 140 ажилтан оролцож Өвөрхангай аймгийн “Арвайн Илч” ХХК-ийн усан халаалтын зуухны газрын үйл ажиллагаатай танилцав.
- Баруун бүсийн нэгдсэн сургалт, семинарыг 2019 оны 5 дугаар сард Завхан аймагт зохион байгуулж Увс, Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймгийн зохицуулах зөвлөлүүд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч 36 компанийн 130 хүний төлөөлөл оролцож Завхан аймгийн “Эл Си Би” ХХК-ийн усан халаалтын зуухны үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцсон.


Сургалт, зөвлөгөөнөөр орон нутгийн дулаан хангамжийн үйл ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, эрчим хүчний хэмнэлтийн бодлого, хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх зэрэг асуудлуудыг хэлэлцэн, цаашид хэрэгжүүлэх ажлуудын талаар зөвлөмж гаргасан юм.

Тайлант хугацаанд аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд 325 удаа хуралдаж тусгай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох болон бусад асуудлаар 258 тогтоол шийдвэрийг гарган хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна. Мөн 2019 онд 38 тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 4 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, 29 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 5 тусгай зөвшөөрөлд өөрчлөлт оруулжээ.



График 21


Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд - ТЗЭ-дийн тоо



Нийт: 265

График 22

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд - Дулааны эрчим хүч хэрэглэгчдийн тоо



ТЗЭ -ийн тоо:


- 2016 онд 194
- 2017 онд 246
- 2018 онд 238
- 2019 онд 265

Дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2019 онд 23133 айл өрх, 2106 үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллага, 1411 төсөвт байгууллагыг 3,755 мян. Гкал дулаанаар хангасан байна. Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн батлан мөрдүүлж буй, хэрэглэгчдэд борлуулах дулааны үнэ тариф 2019 онд айл өрхөд 200-1730 төг/м², үйлдвэр, аж ахуй нэгж, байгууллагад 700 - 1732 төг/м³, төсөвт байгууллагуудад 900-1732 төг/м³ байна.

Айл өрх
ҮААНБ

График 23

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн баталсан дулааны үнэ тариф



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ, ҮР АШИГ

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд заасан эрх үүргийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо нь холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр болон хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлж бүртгэх, тэдгээрт хэмнэлтийг дэмжсэн үйл ажиллагааг идэвхжүүлэх, эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр ажиллах хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, аудитор, менежерийн эрх олгох, мэргэжлийн байгууллагыг магадлан итгэмжлэх, мэргэжлийн үйлчилгээтэй холбоотой харилцааг зохицуулах, хэрэглэгч, олон нийтэд сурталчлан таниулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаа.



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ.

Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбарын болон байгууллага хоорондын уялдааг хангах хүрээнд СЯ, БХБЯ, БОАЖЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ, БСШУЯ, НЗДТГ болон олон улсын байгууллагуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэх, тэдгээр байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлийг тогтоож, талуудын мэдээлэл солилцох уулзалтыг 2019 онд 2 удаа зохион байгуулсан. Энэ ажлын үр дүнд холбогдох яамд, олон улсын байгууллагууд, төсөл хөтөлбөрийн нэгжүүд нэгдсэн ойлголттой болж, үндэсний хөтөлбөрт туссан үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, уялдаа хангагдах нөхцөл бүрдэж байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд Эрчим хүчний

яам болон Хорооны Дотоод аудитын газар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2019 оны хэрэгжилтийг 92.7 %-ийн биелэлттэй гэж дүгнэсэн ба Эрчим хүчний сайдын 2020 оны 03 сарын 09-ний а/810 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, тайлагнасан.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОЖ САЙЖРУУЛАВ.

Эрчим хүчний сайдын зөвлөлийн 2019.04.09 ний хуралдаанаар Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, 2019 оны төлөвлөгөө болон Эрчим хүчний зохицуулах хорооноос хэмнэлтийн чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, тулгамдсан асуудлыг танилцуулж бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн холбогдох шийдвэрийг гаргуулсны үр дүнд Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд заасан “Эрчим хүчний аудит хийх журам”, Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журам”, “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийг тодорхойлох, үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүч хэмнэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрийг боловсруулах аргачлал, хэрэгжилтийг тайлагнах журам”-уудыг тус тус шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2019 оны 181 дүгээр тогтоолоор баталсан.

Журмын шинэчлэлийн хүрээнд Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн “Эрчим хүч хэмнэх үйл ажиллагааны тайланг үнэлэх аргачлал”, эрчим хүчний аудитын тайланг үнэлэх маягт, аудитын мэдээний маягт зэргийг боловсруулж баталснаар үүрэг хүлээсэн хэрэглэгч, аудитор, магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, гүйцэтгэлийг үнэлэх нөхцөл бүрдэж байна.

Мөн түүнчлэн Засгийн газрын 2019 оны 5 сарын 01-ний 182 дугаар тогтоолоор “Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний жилийн хэрэглээний босго хэмжээ”-г шинэчлэн батлуулсан. Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ангилалд 300 кВт.ц/м² жил-ээс дээш эрчим хүчний хэрэглээ бүхий 3000м² ба түүнээс дээш талбай бүхий төрийн болон орон нутгийн төсөвт байгууллага, 5000м² ба түүнээс дээш талбай бүхий бусад аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулснаар Төрөөс Эрчим хүчний талаар





баримтлах бодлого, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр, Ногоон хөгжлийн бодлого зэрэг Монгол улсын хөгжлийн бодлогод тусгагдсан барилгын дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдах нөхцөл бүрдсэн.

- Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9.1.9-г-д заасан Эрчим хүчний хэрэглээний ангилал зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журмын төслийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эцэслэн боловсруулж дууссан бөгөөд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Эрчим хүчний сайдад хүргүүлээд байна. Тус журмын төслөөр эрчим хүчийг үр ашигтай, хэмнэлттэй дэвшилтэт техник, технологийг дэмжих, хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний зарим цахилгаан барааг эрчим хүчний хэрэглээ, үр ашгийн үзүүлэлтээр нь ангилж, зэрэглэл тогтоох, шошгожуулах, түүнтэй холбогдсон үйл ажиллагааны зарчим, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, тэдгээртэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан.
- Хүлэмжийн хийн ялгаралтыг сааруулах Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх Үндэсний зорилтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээнээс ялгарч буй хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах зорилтыг холбогдох бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээтэй уялдуулан ахиулан тодорхойлсон нь хүлэмжийн хийг бууруулахад чиглэсэн сан, олон улсын байгууллага, бусад эх үүсвэрээс хөрөнгө оруулалт татах боломж нэмэгдэж, арга хэмжээнүүдийг бодитой хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлсэн. Уг бодлогын баримт бичгийг Засгийн газрын 2019 оны 407 дугаар тогтоолоор баталсан.
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин,

тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан үйл ажиллагааг дэмжих зохицуулалтыг бий болгох зорилгоор холбогдох саналыг, мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд “Ногоон худалдан авалт” гэсэн шинэ нэр томъёог тусгуулах санал өгсөн нь дэмжигдэж батлагдсан.

- Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаандашиглах боломжтой “Гүйцэтгэлийн гэрээ”-ний загварыг боловсруулж гаргаснаар ЭСКо төслийг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэв. Энэхүү гэрээний загварын дагуу Үүрэг хүлээсэн хэрэглэгчид санхүүгийн дарамт багатайтайгаар хэмнэлтийн арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, хэмнэлтийн төсөл арга хэмжээг ЭСКо төсөл хэлбэрээр хэрэгжүүлснээр гэрээлэгч талуудад үүсэж болох аливаа эрсдэлийг бууруулах, хэрэглэгчид зөвлөмж байдлаар ашиглах боломжтой болсон.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ ОЛОН УЛСЫН СТАНДАРТУУДЫГ ҮНДЭСНИЙ СТАНДАРТ БОЛГОН БАТЛУУЛАВ.

Европын холбоо (EN)-ны эрчим хүчний аудитын EN 16247 стандартын цувралууд, олон улсын цахилгаан техникийн хороо (IEC)-ны цахилгаан хөдөлгүүр болон хүчний трансформаторын үр ашигтай холбоотой IEC 60034, IEC 60034-30-1:2019, IEC 60076-20:2019, IEC 60076-8:2019 стандартууд болон Олон улсын стандартын байгууллага (ISO)-ын эрчим хүчний менежментийн тогтолцооны ISO 50001:2018, ISO 50002:2014, ISO 50003:2014, ISO 50004:2014, ISO 50006:2014, ISO 50007:2017 стандартуудыг үндэсний стандарт болгох ажлыг зохион байгуулж, Стандартчилал хэмжил зүйн газрын дэргэдэх Эрчим хүчний техникийн хороо, менежментийн хороодоор тус тус хэлэлцүүлэн батлуулав.





ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧДИЙГ ТОДОРХОЙЛЖ БҮРТГЭН НЭГДСЭН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТААР ХАНГАН АЖИЛЛАВ.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д заасны дагуу 2019 онд 100 аж ахуйн нэгж байгууллагыг шинээр үүрэг хүлээсэн хэрэглэгчээр тодорхойлж, нийт 229 хэрэглэгчийг бүртгээд байна.

2019 онд үүрэг хүлээсэн хэрэглэгч нэг бүрд хүрч ажиллах зорилт тавин эрчим хүчний салбарын бус үүрэг хүлээсэн 93 байгууллагад ажиллаж тэдгээрийн удирдлагын баг, инженер техникийн 350 орчим ажилтнуудад эрчим хүчний хэмнэлт, үр ашгийн талаар сургалт явуулж, мэдээлэл зөвлөмж өгч ажиллав. Эдгээрээс хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа зарим аж ахуйн нэгж, байгууллагуудад шаардлага хүргүүлж Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллав.

2019 оны байдлаар үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн 80% нь эрчим хүч хэмнэлтийн менежер томилон, эрчим хүч хэмнэлтийн төлөвлөгөө, тайлангаа ирүүлэн ажиллаж байна.



МЕНЕЖЕР БЭЛТГЭЖ МЭРГЭШҮҮЛЭН, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛ ОЛГОВ.

Эрчим хүчний аудитор, эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох, хүчингүй болгох журмын хүрээнд 4 удаагийн сургалт зохион байгуулж 77 эрчим хүч хэмнэлтийн менежерийг шинээр бэлтгэв. Хууль батлагдсанаас хойш барилгын эрчим хүчний 35 аудитор, үйлдвэрлэлийн эрчим хүчний 43 аудитор, эрчим хүч хэмнэлтийн 219 менежер, нийт 376 мэргэжилтэн бэлтгэгдээд байна.

Эрчим хүчний аудитын байгууллага болон эрчим хүчний мэргэжлийн байгууллагад тавих шаардлага, тэдгээрийг магадлан итгэмжлэх журмын дагуу тайлант хугацаанд 3 байгууллагад Эрчим хүчний аудитын магадлан итгэмжлэл олгож, 3 байгууллагын магадлан итгэмжлэлийн хугацааг сунгаад байна.

Хорооноос магадлан итгэмжилсэн эрчим хүчний аудитын 12 байгууллага, Эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх 1 байгууллагын үйл ажиллагаанд тус тус хяналт тавин, хамтран ажиллаж байна.



ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДЛЫГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАН ТАНИУЛАВ.

Нийслэлийн боловсролын газартай байгуулсан хамтран “Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ” хичээлийг Нийслэлийн харьяаны ерөнхий боловсролын 241 сургуулийн 140 мянга гаруй бага ангийн сурагчдад заах үйл ажиллагаа тогтмолжих нөхцөл бүрдэж, тус хичээлийг улс орон даяар дэлгэрүүлэх зорилгоор Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Дорнод аймгуудад сургалт зохион байгуулж, сургагч багш нарыг бэлтгэсэн. Эдгээрээс Дархан-Уул, Дорнод аймгийн 1-5 дугаар ангийн сурагчдад хичээлийг зааж эхэлсэн. Цаашид улсын хэмжээнд тогтмолжуулахаар БСШУСЯ-тай хамтран ажиллаж байна.



Мөн түүнчлэн www.erc.gov.mn цахим системээр дамжуулан үүрэг хүлээсэн хэрэглэгчид, төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн захиргааны байгууллагууд зэрэг 250 гаруй хэрэглэгчээс тайлан, төлөвлөгөөг авах, нэгдсэн дүн шинжилгээ хийх, мэдээлэл солилцох, магадлан итгэмжлэлийн хүсэлтийг авах, аудитор, менежер, мэргэжлийн байгууллагуудыг бүртгэх, олон нийт хэмнэлтийн чиглэлээр хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөөг цаг алдалгүй авах, тасралтгүй хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэв.

ОРОН НУТАГ ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН БОДЛОГОО ТОДОРХОЙЛОН ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЛЭВ.



Орон нутагт эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн удирдлага, аймаг, нийслэлийн Зохицуулах зөвлөл, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг хамруулсан нийт 3 удаагийн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж мэргэжил, арга зүйгээр ханган ажилласнаар орон нутагт хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, төлөвлөх, тайлагнах тогтолцоо бүрдсэн.



Нийт 21 аймагас 12 аймагт Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор тухайн орон нутгийн Эрчим хүч хэмнэх дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үлдсэн 9 аймагт Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг Дэд хөтөлбөрөө боловсруулаад байна.

Мөн Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан Эрчим хүчний хэмнэлтийн талаар мэдлэг олгох, хамтын ажиллагааг эхлүүлэх сургалтыг 2019 оны 11 сард зохион байгуулсан. Тус сургалтад Улаанбаатар хот болон нийт 19 аймгийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүд Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийн талаар нэгдсэн ойлголттой болж хамтран ажиллаж эхлэв.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ, ҮР АШГИЙГ САЙЖРУУЛАХ ХАМТЫН АЖИЛЛАГААНД АХИЦ ГАРАВ.

ГООХАН-ийн “Барилгын эрчим хүчний үр ашиг төсөл”, ДДНХБ, НҮБ-ийн “Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Үндэсний арга хэмжээ төсөл”, БНХАУ-ын “Стандартчиллын үндэсний хүрээлэн”, “Хятадын ЭСКО байгууллагуудын холбоо”, “Эрчим хүчний хэмнэлтийн үндэсний төв” зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэв.



Барилга байгууламжийг эрчим хүчний хэмнэлттэй төлөвлөх, барилга байгууламжийн эрчим хүчний гэрчилгээ олгох, дулааны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр Барилга хот байгуулалтын яамтай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав. Санамж бичгийн хүрээнд барилга байгууламжийг эрчим хүчний үзүүлэлтээр үнэлэн, гэрчилгээ олгох, барилгын материалыг шошгожуулах журмын төслүүдийг тус тус боловсруулав. мөн Монгол улсад барилгын үнэлгээний EDGE системийг нэвтрүүлэхээр Дэлхийн банкны Олон улсын санхүүгийн корпорацтай хамтран ажиллаж байна.

Ногоон зээл, хөрөнгө оруулалт оруулах төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлоход ашиглах “Ногоон таксономи” буюу хүлэмжийн хий, агаар орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааны ангилал, шалгуур үзүүлэлтийг боловсруулах ажлын хэсэгт Монголын банкны холбоо, ТоС Холбоо, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монгол банктай хамтран ажиллав. Улмаар “Ногоон таксономи”-г Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж баталсан юм.

Даян дэлхийн ногоон хөгжлийн байгууллагатай хамтран НАМА буюу хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үндэсний арга хэмжээний 6 дах сонгон шалгаруулалтад угсармал орон сууцыг дулаалах төслийг бэлтгэж, дэмжүүлэв.

ХОРООНЫ 2020 ОНЫ ЗОРИЛТ

Эрчим хүчний зохицуулах хороо нь үндсэн чиг үүрэг, зорилгын хүрээнд 2020 онд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:

- 1 Эрчим хүчний ухаалаг сүлжээ, мэдээллийн технологийг хөгжүүлэх, хэрэглэгчдийг найдвартай, чанартай эрчим хүчээр хангах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах;
- 2 Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд тавих хяналт, чанар, үр нөлөөг дээшлүүлэх, эрсдэлд суурилсан мониторинг хийх;
- 3 Эрчим хүчний үнэ тарифын тогтолцоог сайжруулах, зах зээлийн оновчтой загварыг нэвтрүүлэх боломжийг тодорхойлох;
- 4 Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөр (2018-2022 он)-ийн хэрэгжилтийг хангах, дэвшилтэт техник, технологид суурилсан, эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санаачлах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- 5 Хорооны үйл ажиллагааны удирдлага, гүйцэтгэлийн менежментийг хөгжүүлэх, байгууллага, хамт олны соёлыг төлөвшүүлэх, ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх, өндөр хөгжилтэй улс оронд суралцах боломжийг бүрдүүлэх;

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ЧИГЛЭЛЭЭР

Эрчим хүчний салбарын болон Хорооны үйл ажиллагааг сурталчлах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



Хэрэглэгчдийг салбарын болон зохицуулалтын үйл ажиллагаа, эрчим хүчний хэмнэлтийн талаарх мэдээ, мэдээллээр хангах зорилгоор 101 мэдээлэл, мэдээлэл бэлтгэн, 45

хэвлэл мэдээллийн хэрэгслээр 309 /давхардсан тоогоор/ удаагийн түгээлт хийсэн бөгөөд телевизээр 86, сониноор 33, сайтаар 171, радиод 16, сэтгүүлд 3 социал орчинд 99 мэдээлэл түгээж ажиллажээ. Нийт мэдээллийн 80 гаруй нь Хорооны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл байна.



Эрчим хүчний зохицуулах хорооны цахим сайтыг бүрэн шинэчилж иргэд, хэрэглэгчдэд зориулсан “Эрчим хүчний үнэ цэнэ пэйж хуудас”-ыг хөгжүүлж тус хуудсанд 386 мэдээлэл бэлтгэж түгээсэн.



Эрчим хүчний салбарын санхүү, эдийн засгийн байдал, эрчим хүчний хангамж, аюулгүй ажиллагаа, эрчим хүчний бодит өртөг, үнэ цэнийн талаар олон нийтэд мэдээлэл түгээх ажлын

хүрээнд нийт хэвлэл мэдээллийн 14 байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд олон нийтэд мэдээлэл түгээж ажилласан.



“Эрчим хүчний үнэ цэнэ” пи ар ажлын төлөвлөгөө гарган 3 цуврал нэвтрүүлэг бэлтгэж олон нийтэд хүргэсэн.



Эрчим хүчний үнэ тариф, салбарын тулгамдсан асуудлын хүрээнд 2 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, 5 төрлийн нэвтрүүлэг бэлтгэн нэвтрүүлсэн.



“Эрчим хүчний үнэ цэнэ, тариф”, “Ухаалаг эрчим хүч”, “Сэргээгдэх эрчим хүч” зэрэг сэдэвчилсэн төлөвлөгөөг боловсруулан хэвлэл мэдээллийн байгууллагуудтай

хамтран хэрэгжүүлж, иргэд, хэрэглэгчдэд үнэн бодит мэдээллийг цаг тухайд нь хүргэсэн.



Сэтгүүлчдийн дунд “Эрчим хүчний үнэ цэнэ” сэдэвт уралдааныг зохион байгуулж Эрчим хүчний салбар болон зохицуулалтын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд нийт 119

мэдээ, мэдээллийг үнэ төлбөргүй нэвтрүүлжээ.



ФОТО МЭДЭЭ



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТИЙН ЖИШИГ ТӨСЛИЙГ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ УУЛЗАЛТ БОЛЛО.

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй "Эрчим хүчний үр ашиг 3+" төслийн хүрээнд Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, төрхувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх, эрчим хүчний аудитын мөн чанар, ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах, үүрэг хүлээсэн хэрэглэгчдэд сайн туршлага түгээх, олон нийтэд эрчим хүчний хэмнэлтийн үр өгөөжийг сурталчилах зорилгоор "Дулааны 2-р цахилгаан станц" ТӨХК, "Монголросцветмет" ХХК-ийн Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, "Чингис хаан цогцолбор" ХХК-ийг сонгон авч эрчим хүч хэмнэх төслийг хэрэгжүүллээ. Энэ ажлын хүрээнд "Чингис хаан цогцолбор" ХХК-ийн тэжээлийн усны нацосын цахилгаан хөдөлгүүрүүд дээр давтамж хувиргагч суурилуулах ажлыг төлөвлөсөн хугацаанд амжилттай гүйцэтгэж тус компанид хүлээлгэн өгөх уулзалтыг зохион байгууллаа.



ТӨВИЙН БҮСИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН БОЛЛО

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотод Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийн төвийн бүсийн нэгдсэн зөвлөгөөн боллоо. Зөвлөгөөнд Эрчим хүчний зохицуулах хорооны Тусгай зөвшөөрөл, хяналтын газар, Үнэ тариф, зах зээлийн газар, Эрчим хүчний хэмнэлтийн газар, Хэрэглэгч, орон нутгийн хэлтсийн холбогдох мэргэжилтнүүд, Нийслэл болон Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Булган, Хөвсгөл аймгийн зохицуулах зөвлөлийн гишүүд, эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч 38 компанийн 120 гаруй төлөөлөл оролцсон юм.



"АКУО ЭНЕРЖИ" ГРУППТЭЙ ХАМТАРСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Эрчим хүчний зохицуулах хороо, "Акуо Энержи" групптэй хамтран зохион байгуулсан. Сургалтын үеэр Монгол Улсын цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээнд ашиглах нөөцлүүр эх үүсвэр, цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээний олон улсын загварыг танилцуулж санал солилцсон юм. Сургалтад Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн Үндэсний төв болон эрчим хүчний бусад компаниудын удирдах ажилтнууд болон мэргэжилтнүүд хамрагдсан байна.



“МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТЕХНИКИЙН ХҮЧИН ЗҮЙЛ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН СЕМИНАР БОЛЛОО

“Монгол Улсын эрчим хүчний салбарын техникийн хүчин зүйл” сэдэвт олон улсын семинар “Дулааны цахилгаан станц-3” ТӨХК дээр боллоо. Энэхүү арга хэмжээг Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, “Дулааны 3-р цахилгаан станц” ТӨХК, “Дулааны 4-р цахилгаан станц” ТӨХК хамтран зохион байгуулсан бөгөөд эрчим хүчний үйлдвэр, компаниудын 100 гаруй ажилтан оролцсон байна. Тус семинарт Нийдэрхаймын их сургуулийн доктор, профессор Ёрг Майер, Килийн цахилгаан станцын ашиглалтын албаны дарга Аксел Бёме, “Бенхсхайм инженеринг” ХХК-ийн Ерөнхий менежер, доктор Карстен Брикманн, “Энерсити” ХХК-ийн Худалдан авалт болон стратегийн хөгжлийн хэлтсийн дарга Михаэл Кранц, Берлин хотын “Энерко” ХХК-ийн төлөөлөгч Герберт Франшланд, “Энерсити” компанийн харьяа “Дулааны шийдэл” ХХК-ийн Ерөнхий менежер Манфред Шюле тэргүүтэй гадны төлөөлөгчид оролцож сайн туршлагаасаа хуваалцсан юм.



СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛИНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО

УИХ-ын 2019 оны хаврын чуулганаар Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталлаа. Нэмэлт өөрчлөлтөөр, цахилгаан дамжуулах сүлжээнд холбогдсон нарны эрчим хүчний үүсгүүрээр үйлдвэрлэж нийлүүлэх 1 кВт.ц цахилгаан эрчим хүчний худалдаж авах тарифын дээд хязгаарыг 12 ам.цент хүртэл, салхины эрчим хүчээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг худалдаж авах тарифын дээд хязгаарыг 8 ам.цент хүртэл байх, сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд техникийн асуудлыг анхаарч үзэх, үнээр өрсөлдүүлэх буюу тендер зарлах зэрэг зохицуулалтыг оруулсан юм.



“РЕЛЕ ХАМГААЛАЛТ, АВТОМАТИКИЙН УХААЛАГ ШИЙДЭЛ” УУЛЗАЛТ ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО

Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Диспетчерийн Үндэсний төв хамтран “Реле хамгаалалт, автоматикийн ухаалаг шийдэл” уулзалт зөвлөгөөнийг “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн хурлын танхимд зохион байгууллаа. Зөвлөгөөнд цахилгаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч 30 гаруй компанийн төлөөлөл оролцсон юм.



ДЭЛХИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗӨВЛӨЛИЙН МОНГОЛ УЛС ДАХЬ САЛБАР ХОРООНЫ ХУРАЛ БОЛЛО

Монгол Улс Дэлхийн эрчим хүчний зөвлөлийн гишүүн орноор 2019 онд албан ёсоор элсэн орж салбар хороо байгуулан үйл ажиллагаа явуулж эхлээд байна. Монгол Улс дахь салбар хороо нь эрчим хүчний салбарын төрийн болон эрдэм шинжилгээний байгууллагууд, хувийн хэвшлийн төлөөлөл, төрийн бус байгууллагууд, бусад мэргэжлийн байгууллагын удирдлага, судлаач, шинжээчдээс бүрдэж байгаа бөгөөд тус салбар хорооны ерөнхийлөгчөөр Эрчим хүчний зохицуулах хорооны дарга, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан, зөвлөх инженер, доктор А.Тлейхан, Удирдах зөвлөлийн даргаар Монгол улсын зөвлөх инженер П.Товуудорж нар томилогдон ажиллаж байна.



СОЛОНГОСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ АГЕНТЛАГИЙН ТӨЛӨӨЛӨГЧИД МОНГОЛД АЖИЛЛАВ

БНСУ-ын Эрчим хүчний агентлагийн Ерөнхийлөгч Kim, Chang Seob, Ерөнхий захирал Park, Byung Shoon, Yuun, Chun Suk тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад 2019 оны 7-р сард ажиллав. Төлөөлөгчид Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах хороо, эрчим хүчний зарим үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцсан юм.



БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ ЦАХИЛГААН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТ, ХЭРЭГЛЭЭГ СУДАЛЖ БАЙНА

Эрчим хүчний зохицуулах хороо, Ньюком Групп, “АББ” Групп хамтран Монгол Улсад орчин үеийн, дэвшилтэт, байгальд ээлтэй, шинэ техник технологи нэвтрүүлэх санамж бичигт гарын үсэг зурлаа. Талууд энэхүү санамж бичгийн дагуу “Монгол Улсад орчин үеийн, дэвшилтэт, байгальд ээлтэй, шинэ техник, технологи нэвтрүүлэх, цахилгаан тээврийн хэрэгсэл, түүнийг цэнэглэх дэд бүтэц, цахилгаан хураагуурын хэрэглээг судлах, ашиглалтыг турших, хамтын ажиллагааны үр дүн, ашиглалт, судалгааны үр дүн, мэдээллийг харилцан солилцох”-оор тохиролцсон байна. Санамж бичгийн хүрээнд Ньюком Групп, АББ Групп, Эрчим хүчний зохицуулах хороо нь 100 хувь цахилгаанаар ажилладаг байгальд ээлтэй тээврийн хэрэгсэл, түүний цэнэглэгчийг манай орны эрс тэс уур амьсгалтай цаг уурын нөхцөлд хэрэглэх, ажиглах, турших ажиллагааг албан ёсоор эхлүүлэв.



ХАМТАРСАН КРЕДИТ ОЛГОХ МЕХАНИЗМЫН ХҮРЭЭНД ЯПОН-МОНГОЛЫН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ХОЛБОХ УУЛЗАЛТ, АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Байгаль орчин, уур амьсгалын сангийн дэргэдэх Хамтарсан кредит олгох механизмын нарийн бичгийн газар, Япон улсын Байгаль орчны яам, Хилийн чанад дахь байгаль орчны хамтын ажиллагааны төв байгууллага болон Эрчим хүчний зохицуулах хороо хамтран “Хамтарсан Кредит Олгох Механизм” (ХКОМ)-ын чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд хүлэмжийн хийг бууруулах, байгаль орчинд ээлтэй техник технологи, үйлчилгээг нэвтрүүлэх, боломжит төсөл, хөтөлбөрийг судлах, цаашид хамтран ажиллах сонирхол бүхий Япон, Монгол Улсын бизнес эрхлэгчдийг холбож өгөх уулзалт арга хэмжээг зохион байгууллаа.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАВ

Эрчим хүчний зохицуулах хорооноос аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнүүдэд зориулсан сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалтад Улаанбаатар хот болон нийт 19 аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнүүд оролцсон юм. Сургалтын үеэр “Эрчим хүчний талаар баримталж буй бодлого, өнөөгийн байдал”, “Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль”, “Уур амьсгалын өөрчлөлтийн талаар төрөөс баримталж буй бодлого”, “Эрчим хүч хэмнэх үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах, төлөвлөгөө, тайлан гаргах зөвлөмж”, “Эрчим хүчний хэмнэлт, зохистой хэрэглээ” зэрэг сэдвүүдийн хүрээнд Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны холбогдох албан тушаалтнууд болон мэргэжилтнүүд мэдээлэл өгч, санал солилцсон юм.

УЛААНБААТАР ХОТЫН ДУЛААН ТҮГЭЭХ, ХАНГАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО

Улаанбаатар хотын хэмжээнд дулаан түгээх, хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн зөвлөгөөнийг Эрчим хүчний зохицуулах хороо, “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай хамтран зохион байгуулав. Зөвлөгөөнд, “ДҮТ” ХХК, ОСНААУГ, хувийн хэвшлийн дулаан түгээх, хангах тусгай зөвшөөрөлтэй 60 гаруй компаниудын төлөөлөл оролцсон юм. Зөвлөгөөнөөр 2019-2020 оны халаалтын улирлын оргил ачааллын үед Нийслэлийн хэрэглэгчдийг чанартай, найдвартай дулаанаар хангах асуудлыг хэлэлцэж, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн ажлуудын талаар мэдээлэл солилцсон юм.



ДОРНОД АЙМАГТ “ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ-ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ” СУРГАГЧ БАГШИЙН СУРГАЛТ БОЛЛОО

Эрчим хүчний зохицуулах хорооноос Дорнод аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөл, Боловсрол, соёл, урлагийн газартай хамтран “Эрчим хүчний хэмнэлт-зохистой хэрэглээ” сэдвээр сургагч багшийн сургалтыг 2019 оны 11 дүгээр сарын 07-08-ны өдрүүдэд тус аймагт амжилттай зохион байгууллаа.



ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧДИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН БОЛЛОО

Эрчим хүчний зохицуулах хорооноос эрчим хүч хэмнэлтийн бодлого, хууль эрх зүйн орчин, хуулийн хэрэгжилт, эрчим хүчний салбарын өнөөгийн байдлын талаар үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг мэдээллээр хангах, техник технологи, амжилттай хэрэгжүүлж буй шилдэг туршлага, төслийг танилцуулах, санал солилцох, хамтын ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлж болохуйц арга хэмжээ, шийдлийг хэлэлцэх зорилгоор “ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН ХЭРЭГЛЭГЧДИЙН НЭГДСЭН ЗӨВЛӨГӨӨН”-ийг “Чингис” зочид буудалд зохион байгууллаа. Энэхүү зөвлөгөөнд 2016-2019 онуудад Эрчим хүчний зохицуулах хорооноос тодорхойлж бүртгэсэн, үүрэг хүлээсэн 229 аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцсон бөгөөд эрчим хүчний хэмнэлттэй холбоотой үзэсгэлэн гаргаж танилуулав.



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГТ ОРОЛЦОВ

Монгол Улсын Засгийн газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласны дагуу Эрчим хүчний салбарын нээлттэй хаалганы өдөрлөгт Хорооны хамт олон оролцож, үнэ тариф, тусгай зөвшөөрөл, эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр хэрэглэгчдэд мэдээ, мэдээлэл өгч, хэрэглэгчдийн гомдол саналыг хүлээн авч, зарим асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажиллав.

“ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАР ДАХЬ УХААЛАГ ШИЙДЛҮҮД-2019” НИЙТЛЭЛ, ИЛТГЭЛИЙН УРАЛДААН БОЛЛОО

“Ухаалаг эрчим хүч”-ний жилийн хүрээнд Эрчим хүчний зохицуулах хороо, Эрчим хүчний хөгжлийн төв, Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв, Диспетчерийн үндэсний төв, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн зэрэг байгууллагууд хамтран “Эрчим хүчний салбар дахь ухаалаг шийдлүүд-2019” нийтлэл, илтгэлийн уралдааныг монгол, англи хэл дээр зарлаж, дүгнэв. Илтгэлийн уралдаанд нийт 22 багш, инженерүүд бүтээлээ ирүүлсэн юм.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТТЭЙ ОФФИСЫН ШИНЭ БАРИЛГА АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА

Эрчим хүчний зохицуулах хороо нь 1960-аад онд баригдсан хуучин оффисын барилгаа буулгаж суурин дээр нь эрчим хүчний хэмнэлттэй, дулааны алдагдалгүй, сэргээгдэх эрчим хүчээр цахилгааны хэрэглээний зохих хувийг хангадаг, Халаалтын автомат үзэлээр тоноглогдсон, цахилгаан машин цэнэглэх боломжтой оффисын шинэ барилгыг ашиглалтад орууллаа. Тус барилгын дээр 30 кВт-ын хүчин чадалтай нарны эх үүсгүүр байрлуулсан бөгөөд Эрчим хүчний зохицуулах хорооны цахилгаан эрчим хүчний нийт хэрэглээний 40 гаруй хувийг сэргээгдэх эрчим хүчээр хангах боломжтой юм.